

МОНГОЛЫН
АНАГААХ
УХААН

1996
№ 1

МОНГОЛЫН АНАГААХ УХДАН

Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам, Монголын эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн улирал тутмын сэтгүүл

37 дахь жилдээ

№1 (94)

1996 он

ГАРЧИГ

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Г.Сүхбат, О.Амарцэнгэл, Г.Батмэнх, Г.Дашзэвэг Хүмүүнлэг чанарын сорилоор ирээдүйн мэргэжилтэнг сонгох боломж 3

С.Татьяана, Б.Бурмаа, Т.Тунгалаг, А.Чойгалжамц, Ц.Адъяахүү, Ц.Жаргалсайхан, И.Наранцэцэг, Т.Нансалмаа Хүүхдийн биеийн галбирын зарим үзүүлэлт, өөрчлөлтийг судалсан дүн..... 7

Л.Нарантуяа, Ш.Энхцэцэг, Л.Пурэвжав, Т.Тойвгоо, Г.Туваанжав, А.Батхишиг Үндны усны найрлага дах биоидэвхт зарим элементүүдийн агууламжийг хүн амын холбогдох өвчлөлттэй харьцуулан судалсан дүн..... 13

Л.Энхбаатар, Л.Лхагва Монгол орны тарваган тахлын дэгдэлтүүдэд байгалийн хүчин зүйлийн нэлөөг судалсан дүн..... 26

ЛЕКЦ, ТОЙМ, ЗӨВЛӨЛГӨӨ

П.Нямдаваа, Г.Дашзэвэг Монгол улсын эрүүл мэндийн бодлогын түүхэн хөгжил, хэтийн төлөв..... 3

Өгүүллүүдийн англи товчлол..... 45

1995 онд анагаах ухааны чиглэлээр зэрэг хамгаалсан эрдэмтэд 47

MONGOLIAN MEDICAL SCIENCES

Quarterly journal of the Ministry of Health Mongolia and
the Scientific Society of Mongolian Physicians

37 th year of publication No1 (94) 1996

CONTENTS

ORIGINAL ARTICLES

- G.Sukhbat; O.Amartsengel, G.Batmunkh, G.Dashzeveg Possibilities of usage of humanity tests in the selection of future specialists.....3
- S.Tatyana, B.Burma, T.Tungalag, A.Choigoljamts, Ts.Adyahuu, Ts.Jargalsaikhan, I.Narantsetseg, T.Nansalma The results of a study on curvature of spine of mongolian children.....7
- L.Narantuya, Sh.Enkhtsetseg, L.Toiwgo, G.Tuwanjaw, A.Bathishig The results of a study on correlations of contents of bio-active elements in the drinking water and morbidity of population13
- L.Enkhbaatar, L.Lkhagwa Study of influences of some natural factors on plague outbreaks in Mongolia26

LECTURE, REVIEWS AND CONSULTATIONS

- P.Nymadawa, G.Dashzeveg The historical development and future trends in health policy of Mongolia33
- Abstracts of the articles in English..... 45
- Scientists established medical doctoral and philosophy doctoral degrees in 1995 47

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

ХҮМҮҮНЛЭГ ЧАНАРЫН СОРИЛООР ИРЭЭДҮЙН МЭРГЭЖИЛТЭНГ СОНГОХ БОЛОМЖ

**Г.Сүхбат, О.Амарцэнгэл, Г.Батмөнх, Г.Дашзэвэг
Анагаах Ухааны Их Сургууль**

Хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах Монгол Улсын зорилт хүн ард нь хир зэрэг хүмүүнлэг байгаа эсэхээс л хамаарна.

Маргаашийн хүмүүнлэг нийгмийг байгуулах анхны хүмүүс нь өнөөдрийн оюутан залуус билээ. Бие хүн нь удамшил ба сэтгэцийн шинжүүдийг багтаасан сэтгэц-бие зүйн суурин дээр тулгуурлан хөгждөг учир хүмүүнлэг чанараараа хүмүүс харилцан адилгүй. Хүний нийгмийн хөгжлийн түүхээс харахад хамгийн хүмүүнлэг байх ёстой мэргэжилтэн нь эмч гэж үздэг.

Судалгааны аргачлал

Энэ бүхэнд тулгуурлан бид хүний хүмүүнлэг чанарыг тодорхойлох сэтгэл зүйн сорил боловсруулан АУИС-ийн оюутнууд, тус сургуульд элсэгчид болон шилдэг эмч наарт судалгаа явуулж, өөрсдийн боловсруулсан сорилын амьдралд хэрэгжих боломжийг тогтоосон юм. Улмаар энэхүү сорилоо сэтгэл зүйн бусад аргуудтай хавсрсан хэрэглэж Монгол Улсын их сургуулиудын оюутнуудын хүмүүнлэг чанарыг тодорхойлж ирээдүйн мэргэжилтийг шилж сонгох нэгэн үндэслэл гаргах зорилт тавилаа. Судалгаанд 5 их сургуулийн (МУУИС, АУИС, ХААИС, УБИС, ТИС) 18-25 насны 1440 оюутанд (эмэгтэй 992, эрэгтэй 448) судалгаа явууллаа. Эрүүл мэндэд хандах байдлыг С.Долецкийн, зан араншиг Смирновын, хүмүүнлэг чанарыг өөрсдийн боловсруулсан сорилоор тус тус тодорхойлж хүйс, мэргэжил, элсэлтийн байдалтай холбон авч үзлээ.

Судалгааны дүн, зөвшлөг

Хүмүүнлэг чанарын сорилоор тэнцүүлэн авч үзэхэд: Эрэгтэйчүүдийн $25.2 \pm 2.0\%$ тэнцэхгүй, тэнцэх боломжтой

$63.6 \pm 2.3\%$, бүрэн тэнцэх нь $11.2 \pm 1.5\%$ байхад эмэгтэйчүүдийн дотор тэнцэхгүй $25.4 \pm 1.4\%$, тэнцэх боломжтой $63.8 \pm 1.5\%$ бүрэн тэнцэх $10.8 \pm 1.0\%$ байв.

Мэргэжлийн онцлогтой холбон судалж үзэхэд:

Анагаахын мэргэжлийн оюутнууд хүмүүнлэг чанараар $18.68 \pm 2.4\%$ тэнцэхгүй, $21.72 \pm 1.8\%$ тэнцэх боломжтой. $43 \pm 4.71\%$ нь бүрэн тэнцэж байхад Техникийн мэргэжлийн оюутнуудын $21.02 \pm 2.54\%$ тэнцэхгүй, $13.47 \pm 1.34\%$ тэнцэх боломжтой, $8.04 \pm 2.57\%$ бүрэн тэнцэж, Нийгмийн ухааны оюутнуудын $7.78 \pm 1.67\%$ тэнцэхгүй, $7.89 \pm 1.0\%$ тэнцэх боломжтой, $3.57 \pm 1.75\%$ бүрэн тэнцэж (энд зөвхөн 3 үндсэн мэргэжлийг төлөөлүүлэн сонгож авсан болно) байна.

Үүнээс үзэхэд анагаахын мэргэжлийн оюутнуудын дотор хүмүүнлэг чанараараа бүрэн тэнцэх хүмүүс мэдэгдэхүйц давамгай байхад техникийн мэргэжлийн оюутнуудын ихэнх нь, нийгмийн ухааны чиглэлийн оюутнуудын нэлээд нь хүмүүнлэг чанараараа тэнцэхгүй гэсэн бүлэгт хамрагдаж байна. Энэ нь хүмүүнлэгийн талаар явуулах ажлын чиглэлийг төдорхойлох нэгэн чухал үндэслэл болох боломжийг нээж байна.

Хүмүүнлэг чанарын сорилоор хот, хөдөөнөөс ирсэн байдалтай уялдуулан хүйсээр хамруулж авч үзвэл, нийт тэнцэхгүй эрэгтэй хүмүүсийн 42.7% , хотынх 57.3% , хөдөөнийх тэнцэх боломжтой хүмүүс хот, хөдөөд адилхан 50% бүрэн тэнцэх хүмүүсийн 49.1% , хотынх 50.9% , хөдөөнийх байна. Эмэгтэйчүүдийн хувьд бүх тэнцэхгүй хүмүүсийг 100% гэж үзвэл хотынх 50.9% хөдөөний 45.4% эзэлж байхад тэнцэх боломжтой нь 47.3% хотынх 52.7% хөдөөнийх, бүрэн тэнцэх хүмүүсийн 47% хотынх, 53% хөдөөнийх байна. Үүнээс харахад хүмүүнлэг байдлаараа тэнцэхгүй эмэгтэйчүүдийн ихэнх нь хотынх, харин эрэгтэйчүүдийн олонхи нь хөдөөнийх байгаа нь тогтоогдлоо. Эрүүл мэнддээ хэрхэн хандах хандлагыг хүмүүнлэг чанартай уялдуулан нэгдүгээр хүснэгтээр үзүүлэв.

Ер нь манай оюутан залуус эрүүл мэнддээ хандах байдал хангалтгүй байгаа нь сэтгэл эмзэглүүлж байгаа хэдий ч хүмүүнлэг чанар нь сайжрах тутам эрүүл мэнддээ хандах байдал нь эрчимждэг ихээхэн сонирхолтой зүй тогтолыг анх удаа илрүүллээ.

Хүмүүнлэг чанар болон хүний араншигийн уялдааг хоёрдугаар хүснэгтээр үзүүлэв.

Эмэгтэйчүүдийн хувьд хүмүүнлэг чанар нэмэгдэх тутам санаа бодлоо илэрхийлэх чадвар мэдэгдэхүйц ($P < 0.001$) нэмэгдэж

Хүснэгт №1

**ХҮМҮҮНЛЭГ ЧАНАР ЭРҮҮЛ МЭНДДЭЭ ХАНДАХ БАЙДАЛД
НӨЛӨӨЛӨХ НЬ**

Хүмүүнлэг чанар		Эрүүл мэнддээ хандах байдал		
		хангалтгүй	дунд зэрэг	хангалттай
тэнцэхгүй	эр	85.8±3.3	8.8±2.7	5.3±2.0
	эм	90±1.9	6.4±1.5	3.6±1.2
тэнцэх боломжто	эр	81.3±2.3	6.7±1.5	1.2±1.9
	эм	85.3±1.4	7.9±1.0	6.8±1.0
бүрэн тэнцэх	эр	68.6±6.5	11.8±4.5	19.6±5.5
	эм	64.2±4.6	17.4±3.6	18.4±3.7

харин хатан чанар сайжрах хандлага ажиглагдсан ч үнэн магадтай ялгаа илэрсэнгүй. Мөн сэтгэл хөдлөлийн хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдсангүй. Тэнцэх боломжтой болон бүрэн тэнцэх хүмүүс тэнцэхгүй хүмүүсээс хариу урвалын хурдаараа илүүтэй байна. Хүмүүнлэг чанар сайжрах тутам идэвхтэй байдал улам ($P<0.001$) нэмэгдэж байна. Эрэгтэйчүүдийн хувьд дээрхи зүй тогтол нэгэн адил илэрч байна. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн аравны нэг орчим нь хүмүүнлэг чанарын хувьд хангалтгүй байгаа бөгөөд мэргэжлээр нь авч үзвэл Анагаахын оюутнууд илүү хүмүүнлэг , харин Техникийн хүмүүс хүмүүнлэг чанар багатай байна.

2. Хүмүүнлэг чанараар тэнцэхгүй эмэгтэйчүүдийн ихэнх нь хотынх, эрэгтэйчүүдийн олонхи нь хөдөөнийх байна.

3. Хүмүүнлэг чанар нь сайжрах тутам тэдний эрүүл мэнддээ хандах байдал, санаа бодлоо илэрхийлэх чадвар, идэвхтэй байдал болон хариу урвалын хурд нь нэмэгдэж амьдралын идэвхтэй байх суурь эзлэх таатай боломж бурдэж байна.

Тайынбар: 2 - мүү, 3 - дүңд, 4- сайд

Хүснүүр №2

ХАМЫНДЫЛ ЖЕЛДАРДА АРАЛЫКТАРЫНЫН СИМВОЛДАРЫНЫН КАРГЫЛАУУЛАДАК ЕАМЫЛАУ

Хамындардын түрү	Саны	Максимум		Минимум		МК мкг/кг	МК мкг/кг
		МК мкг/кг	МК мкг/кг	МК мкг/кг	МК мкг/кг		
Сандыкчылар	2	49.5±5	48.9±3.4	34.1±3.0	32.9±1.9	20±5.6	20±4.0
Сандыкчылар	3	24.3±4	32.2±3.2	28.4±2.4	26.7±1.8	20±5.6	26±4.4
Сандыкчылар	4	26.2±4	18.0±2.6	37.5±1.7	40.2±2.0	60±6.9	53.5±5.0
Сандыкчылар	2	11.7±3	6.5±1.7	6.5±1.5	6.9±1.0	6±3.4	11±3.2
Сандыкчылар	3	29.1±4.5	28.5±3.1	30.3±2.8	30.3±1.9	28±6.3	29±4.6
Сандыкчылар	4	58.2±4.8	65.0±3.2	63.2±3	62.8±2.0	66±6.7	59.6±4.9
Сандыкчылар	2	19.5±4	12.9±2.3	26.8±2.7	17.9±1.6	30±6.5	19±2±4.0
Сандыкчылар	3	55.3±5	55.3±3.4	56.3±3	61.9±2.0	54±7	66.7±4.7
Сандыкчылар	4	25.2±4	31.8±3.2	16.9±2.3	20.2±1.7	16±5	14±3.5
Халыктын күрд	2	39.8±4.8	42.9±3.4	23.4±2.6	29.1±1.9	20±5.6	25.2±4.4
Халыктын күрд	3	37.9±4.8	37.8±3.3	49±3	44.2±2.1	48±7	46.5±5.0
Халыктын күрд	4	22.3±4	19.3±2.7	27.6±2.7	26.7±1.8	32±6.6	28.3±4.5
Халыктын күрд	2	24.3±4	24.9±2.9	11.5±2	16.4±1.5	2±1	7.1±2.6
Халыктын күрд	3	55.3±5	58.1±3.4	56.7±3	57.0±2.1	44±7	53.5±5.0
Халыктын күрд	4	20.4±4	17.3±2.6	31.8±2.8	26.6±1.8	54±7	39.4±4.9

НОМ ЗҮЙ

1. Анагаах ухааны дервэн үндэс (1991) УБ 735 х
2. Воробейчик П.Н., Покитер Е.А., (1989) Основы психогигиены Киев. 183 с
3. Под ред Щебанова А.И М (1990) Практикум по общей психологий 285 с
4. Майдикова Ю.Л., Майоренко П.П., (1991) Роль психофизиологических и личностных особенностей человека в условиях групповой деятельности. Комференция. Индивидуальные психофизиологические особенности человека и профессиональная деятельность, Черкассы. 156 с
5. Action and Action Competence as key Concepts in critical Pedagogy Royal Dahish School of Educational Studies (1994) p 224

ХҮҮХДИЙН БИЕИЙН ГАЛБИРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДАЛСАН ДҮН

С.Татьяна, Б.Бурмаа, Т.Тунгалаг, А.Чойголжамц,
Ц.Адъяахүү, Ц.Жаргалсайхан, И.Наранцэцэг,
Т.Нансалмаа

Эрүүл ахуй, Халдвэр нян судлалын үндэсний төв, Увс, Ховд,
Өвөрхангай, Булган, Архангай аймаг, Улаанбаатар хотын
Эрүүл ахуй Халдвэр судлалын хяналтын газар

Биеийн галбир нь хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийн нэг үзүүлэлт бөгөөд тэдний өсөлт хөгжлийн шат бүрд өөр өөр байдаг. Хүүхдийн байгууллагын модон эдлэл (самбар, парт, ширээ, сандал, ор) хувцас хэрэглэл нь хүүхдийн биеийн хэмжээ, суудал, хэвтэр зэрэг байдал тохироогүй бол тэдний бие бялдрын өсөлт хөгжил, биеийн галбир, яс, булчин, харааны эрхтний үйл ажиллагаа, сурлагын чанарт муугаар нөлөөлдөг.

Оросын эрдэмтэн З.П.Ковалькова орос хүүхдийн нурууны өндөр, хүзүүний тахирын гүн, ууцны хотгорын гүний хэвийн хэмжээ, нурууны хэлбэрийн гаж өөрчлөлтийг судлан тогтоожээ.

Манай улсад хүүхэд өсвөр үеийнхний биеийн галбир, нурууны хэлбэрийн өөрчлөлт нэлээд ажиглагддаг боловч монгол хүүхдийн нурууны өндөр, хүзүүний тахир, ууцны хотгорын гүний хэвийн хэмжээ, түүний гаж өөрчлөлтийг судалсан судалгаа, шинжилгээний хэвлэлийн материал ховор байгаагаас хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийн байдалд эрүүл ахуйн иж бүрэн

үнэлгээ ёгч, дүгнэлт гаргах боломжгүй байна.

Судалгааны зорилго:

Монгол улсын сургуулийн насны хүүхдийн нурууны өндөр, хүзүүний тахир, ууцны хотгорын гүний хэмжээ, сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн биеийн галбирын өөрчлөлтийг судалж, жишиг үзүүлэлт боловсруулах, эрүүл ахуйн үнэлгээ ёгех.

Судалгааны арга зүй

Нийт аймаг, хотын Эрүүл ахуй, халдварт судлалын хяналтын газрын хүүхэд есвэр үеийн эрүүл ахуйч эмч нарыг оролцуулан ЭАХС-ын Улсын ерөнхий байцаагчийн 1992 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 42 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу 1992-1994 онд хэмжилт, судалгаа явуулж, газар зүйн мужлалаар ангилан дүн шинжилгээ хийж, эрүүл ахуйн үнэлгээ ёглөө.

Хүүхдийн нурууны өндөр, хүзүүний тахирын гүн, ууцны хотгорын гүний хэмжээг З.П.Ковальковагийн аргаар, биеийн галбирын өөрчлөлтийг Е.Рутковскаягийн сорилоор тус тус судаллаа.

Судалгааны үр дүн

Сурагчдын нурууны өндөр, хүзүүний тахир, ууцны хотгорын гүний хэмжээг Алтайн уулархаг, Хангайн мужид судалсан дүнг 1, 2 дугаар хүснэгтээр харуулав. Алтайн уулархаг мужийн 8-17 насны 1010 эрэгтэй, 1048 эмэгтэй сурагчдыг судалгаанд хамруулан хийсэн судалгааны дүнгээс үзэхэд (Хүснэгт 1) нурууны өндөр хүүхдийн нас ахих тутам нэмэгдэж 55.8-76.5 см (эрэгтэй, 54.6-76.3 см(эмэгтэй) , хүзүүний тахирын гүн 2.8-3.3 см (эрэгтэй), 2.79-3.37 см (эмэгтэй), ууцны хотгорын гүний хэмжээ 2.7-3.3 см (эрэгтэй), 2.7-3.4 см(эмэгтэй), Хангайн мужийн 8-13 насны 758 эрэгтэй, 8-17 насны 1468 эмэгтэй хүүхдийг судалсан дүнгээр (Хүснэгт №2) нурууны өндөр 58.6-73.5 см (эрэгтэй), 59.4-76.3 см(эмэгтэй), хүзүүний тахирын гүн 2.8-3.5 см (эрэгтэй), 2.8-3.0 см (эмэгтэй), ууцны хотгорын гүн 2.25-2.95 см (эрэгтэй), 2.2-2.91 см (эмэгтэй) тус тус байна.

Алтайн уулархаг, Хангайн мужийн хүүхдийн нурууны өндөр, хүзүүний тахир, ууцны хотгорын гүний хэмжээг харьцуулахад Алтайн уулархаг мужийн 8,9,10 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд

Хангайн мужийн ижил насны хүүхдүүдээс 061-4.72 см-ээр нам, 10,11 насны эрэгтэй, эмэгтэй , 12,14,16 насны эмэгтэй хүүхдүүд 0.02-1.23 см-ээр өндөр боловч энэхүү ялгаа нь 8 насны эмэгтэй ($t>2$)-гээс бусад насанд үнэн магадтай биш байна.

Хоёр мужийн хүүхдийн хүзүүний тахирэн гүний хэмжээг харьцуулан судлахад бараг бүх насанд Хангайн мужийн хүүхдүүд Алтайн уулархаг мужийн хүүхдүүдээс 0.01-0.67 см-ээр илүү ($t<2$) , ууцны хотгорын гүний хэмжээгээр бүх насанд Хангайн мужийн хүүхдүүд Алтайн уулархаг мужийн хүүхдээс 0.02-1.01 см-ээр илүү бөгөөд энэ ялгаа нь 9 насны эрэгтэй, 14 насны эмэгтэйгээс ($t>2$) бусад насанд үнэн магадтай биш байна.

Е.И.Вареничийн (1974) тэмдэглэснээр Польсья суурины хөвгүүдийн 17.6 хувь, охидын 24.2 хувь нуруу нугалмайн хэв гажсан, Ч.Цолмонгийн судалгаагаар 8-17 насны охидын дунд нуруу, нугалмайн гажиг 5.8 хувь, хөвгүүдийн дунд 16.2 хувь байгааг тус тус тогтоосон байна.

Хүүхдийн биеийн галбирын өөрчлөлтийг Архангай, Өвөрхангай, Булган, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Хөвсгөл, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын 14178 хүүхдийг хамруулан судалж аргачлалын дагуу үнэлгээ өгөхөд судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 83.7 хувь нь хэвийн, 14.64 хувь нь бага зэргийг өөрчлөлттэй, 1.63 хувь нь мэдэгдэхүйц өөрчлөлттэй байна.

Е.И.Варенич нарны олон судлаач хүүхдийн нуруу, нугалмай гажих нь сургуулийн өмнөх насанд эхэлж байгааг ажигласан байна. Тухайлбал 7 настайд хөвгүүдийн 19.4 хувь , охидын 74 хувь нуруу, нугалмайн хэв гажсан байсныг тэмдэглэжээ.

Хүүхдийн биеийн галбирын өөрчлөлтийг Улаанбаатар хотод судалсан дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан сургуулийн 704 хүүхдийн 526 буюу 74.7 хувь нь , цэцэрлэгийн 284 хүүхдийн 172 буюу 60.6 хувь нь тус тус биеийн галбир, тулгуур эрхтний өөрчлөлттэй байна. (Хүснэгт №3)

Сургуулийн ба сургуулийн өмнөх насны хүүхдийн биеийн галбирын өөрчлөлтийг харьцуулахад сургуулийн хүүхдүүд биеийн галбирын гаж өөрчлөлтөөр цэцэрлэгийн насны хүүхдээс 14.1 хувиар ($t>2$) илүү байна. Хүүхдийн биеийн галбирын өөрчлөлтийг судалсан үзүүлэлт бүрээр сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдийг харьцуулахад 4 дүгээр хүснэгтийн 5,6,7 дугаар үзүүлэлтээр цэцэрлэгийн насны хүүхдүүд сурагчдаас илүү ($t>2$), сурагчид цэцэрлэгийн насны хүүхдээс 3,4 дүгээр үзүүлэлтээр илүү ($t>2$) байна.

ДҮГНЭЛТ

1. Монгол хүүхдийн (сургуулийн насы) нурууны өндөр, хүзүүний тахирын гүн, ууцны хотгорын гүний хэмжээг урьдчилсан байдлаар тогтоос.
2. Монгол хүүхдийн хүзүүний тахирын гүн нь бүх насанд ууцны хотгорын гүнээс илүү, хүүхдүүд бөгтөрдүү байна.
3. Алтайн уулархаг, Хангайн мужийн хүүхдүүд нурууны өндөр, хүзүүний тахир, ууцны хотгорын гүний хэмжээгээр ялимгүй ялгаатай боловч үнэн магадтай биш байна
4. Биеийн галбирын өөрчлөлтийг судлахад нийт хүүхдийн 83.7 хувь нь хэвийн, 14.64 хувь нь бага зэргийн, 1.63 хувь нь мэдэгдэхүйц өөрчлөлттэй байна.
5. Сургуулийн насы хүүхэд сургуулийн өмнөх насын хүүхдээс биеийн галбирын өөрчлөлтөөр илүү ($t > 2$) байна.

САНАЛ:

1. Монгол хүүхдийн нурууны өндөр, хүзүүний тахирын гүн, ууцны хотгорын гүний хэмжээ, хэлбэрийг нарийвчлан судалж, тогтоох.
2. Хүүхдийн биеийн галбир, нуруу нугалмайн хэлбэрийн гаж өөрчлөлийг түүнд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлүүдтэй холбон судалж, цаашид хүүхдийн биеийн галбирын гаж өөрчлөлтөөс сэргийлэх аргыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсронгуй болгох шаардлагатай байна.
3. Хүүхдийн нурууны гаж өөрчлөлтэд нөлөөлех сөрөг хүчин зүйлийн нэг болох ширээ, сандал зэрэг хүүхдийн зориулалттай бүх төрлийн модон эдлэлийг батлагдсан стандарт, зааврын дагуу үйлдвэрлэх үйлдвэр байгуулах.
4. Хүүхдийн бие бялдрын өсслэл хөгжлийг орчин үеийн түвшинд судлах судалгааны арга барилд энэ мэргэжлээр ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийг сургах, судалгаанд шаардлагатай багаж төхөөрөмжжөөр хангах асуудлыг шийдвэрлэх.
5. Хүүхдийн зөвлөх төв, гэмтэл согогийн эмнэлэгт хүүхэд есвэр үеийн биеийн галбирын өөрчлөлтийг засах, эмчлэх, зөвлөлгөө өгөх мэргэжлийн эмчийг бэлтгэн ажилуулж, хөдөө, орон нутгийн эмч нарыг мэргэжлийн арга барилаар хангах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Хуснэгт №1

**АЛТАЙН УУЛАРХАГ МУЖИЙН 8-17 НАСНЫ ХУУХДИЙН
НУРУУНЫ ӨНДЕР, ХУЗУЧНИЙ ТАХИР, УЦЫН ХОТТОРЫН
ГҮНИЙ ХЭМЖЭЭГ СУДАЛСАН ДҮН**

Нас	Хүйс	Хуухдийн тоо	Нурнууын өндөр(см)	Хуягчийн тахидын гүнх хотторын гүнх (см)	Уцын гүнх хотторын гүнх хотторын гүнх (см)		Мжт	Мжт	Уцын гүнх хотторын гүнх хотторын гүнх (см)
					Нас	Хүйс	Хуухдийн тоо	Нурнууын өндөр(см)	Хуухдийн гүнх хотторын гүнх (см)
8	эр	99	55.77±1.73	2.85±0.30	2.71±0.35	эр	146	58.59±1.62	2.82±0.32
	эм	94	54.64±1.24	2.75±0.28	2.66±0.37	эм	147	59.36±1.54	2.84±0.35
9	эр	128	59.28±1.26	3.29±0.32	3.18±0.37	эр	132	60.17±0.93	2.90±0.71
	эм	120	57.94±1.62	3.18±1.10	3.0±0.86	эм	165	60.93±1.16	3.06±0.34
10	эр	131	63.43±1.28	3.24±0.29	3.17±0.34	эр	142	63.21±0.95	2.57±0.47
	эм	136	62.92±1.60	3.40±0.39	3.10±0.56	эм	173	62.05±1.60	2.73±0.37
11	эр	96	65.62±1.72	3.70±0.37	3.37±0.42	эр	123	64.39±1.08	3.09±0.34
	эм	112	64.45±2.04	3.47±0.43	3.36±0.44	эм	145	63.62±0.50	2.99±0.34
12	эр	92	65.54±1.15	3.22±0.30	3.08±0.27	эр	110	66.08±1.15	3.06±0.85
	эм	123	66.14±1.85	3.17±0.30	2.95±0.32	эм	140	66.12±1.45	3.06±0.34
13	эр	118	69.45±2.26	3.50±0.43	3.34±0.40	эр	106	73.45±1.55	3.49±0.82
	эм	115	68.09±1.54	3.35±0.33	3.28±0.37	эм	122	70.63±0.46	2.93±0.68
14	эр	111	70.22±1.42	3.51±0.42	3.00±0.58	эр	-	-	-
	эм	109	70.03±2.01	3.48±0.41	3.02±0.26	эм	14	69.82±1.13	3.16±0.56
15	эр	78	73.79±2.76	3.35±0.37	3.43±0.38	эр	15	74.33±1.17	3.06±0.30
	эм	62	71.98±1.46	3.50±0.44	3.50±0.46	эм	202	-	2.55±0.39
16	эр	79	74.95±2.26	3.29±0.36	3.54±0.37	эр	16	-	-
	эм	81	74.48±1.52	3.40±0.40	3.42±0.41	эм	136	74.02±0.50	2.99±0.42
17	эр	78	76.52±1.60	3.27±0.30	3.28±0.34	эр	17	-	-
	эм	76	76.26±2.43	3.37±0.34	3.40±0.40	эм	75	76.27±21.02	3.45±0.46

Хуснэгт №2

ХАНГАЙН МУЖИЙН 8-17 НАСНЫ ХУУХДИЙН НУРУУНЫ ӨНДЕР, ХУЗУЧНИЙ ТАХИР, УЦЫН ХОТТОРЫН ГҮНИЙ ХЭМЖЭЭГ СУДАЛСАН ДҮН

Нас	Хүйс	Хуухдийн тоо	Нурнууын өндөр(см)	Хуягчийн тахидын гүнх хотторын гүнх (см)	Уцын гүнх хотторын гүнх хотторын гүнх (см)		Мжт	Мжт	Уцын гүнх хотторын гүнх хотторын гүнх (см)
					Нас	Хүйс	Хуухдийн тоо	Нурнууын өндөр(см)	Хуухдийн гүнх хотторын гүнх (см)
8	эр	99	55.77±1.73	2.85±0.30	2.71±0.35	эр	146	58.59±1.62	2.82±0.32
	эм	94	54.64±1.24	2.75±0.28	2.66±0.37	эм	147	59.36±1.54	2.84±0.35
9	эр	128	59.28±1.26	3.29±0.32	3.18±0.37	эр	132	60.17±0.93	2.90±0.71
	эм	120	57.94±1.62	3.18±1.10	3.0±0.86	эм	165	60.93±1.16	3.06±0.34
10	эр	131	63.43±1.28	3.24±0.29	3.17±0.34	эр	142	63.21±0.95	2.57±0.47
	эм	136	62.92±1.60	3.40±0.39	3.10±0.56	эм	173	62.05±1.60	2.73±0.37
11	эр	96	65.62±1.72	3.70±0.37	3.37±0.42	эр	123	64.39±1.08	3.09±0.34
	эм	112	64.45±2.04	3.47±0.43	3.36±0.44	эм	145	63.62±0.50	2.99±0.34
12	эр	92	65.54±1.15	3.22±0.30	3.08±0.27	эр	110	66.08±1.15	3.06±0.85
	эм	123	66.14±1.85	3.17±0.30	2.95±0.32	эм	140	66.12±1.45	3.06±0.34
13	эр	118	69.45±2.26	3.50±0.43	3.34±0.40	эр	106	73.45±1.55	3.49±0.82
	эм	115	68.09±1.54	3.35±0.33	3.28±0.37	эм	122	70.63±0.46	2.93±0.68
14	эр	111	70.22±1.42	3.51±0.42	3.00±0.58	эр	14	-	-
	эм	109	70.03±2.01	3.48±0.41	3.02±0.26	эм	163	69.82±1.13	3.16±0.56
15	эр	78	73.79±2.76	3.35±0.37	3.43±0.38	эр	15	74.33±1.17	3.06±0.30
	эм	62	71.98±1.46	3.50±0.44	3.50±0.46	эм	202	-	2.55±0.39
16	эр	79	74.95±2.26	3.29±0.36	3.54±0.37	эр	16	-	-
	эм	81	74.48±1.52	3.40±0.40	3.42±0.41	эм	136	74.02±0.50	2.99±0.42
17	эр	78	76.52±1.60	3.27±0.30	3.28±0.34	эр	17	-	-
	эм	76	76.26±2.43	3.37±0.34	3.40±0.40	эм	75	76.27±21.02	3.45±0.46

Хүснэгт3
УЛААНБААТАР ХОТЫН ХҮҮХДИЙН БИЕИЙН ГАЛБИРЫН
ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДАЛСАН ДҮН

Галбирын өөрчлөлтийг судалсан үзүүлэлт	Биеийн галбирын өөрчлөлттэй хүүхед			
	Цэцэрлэгийн		Сургуулийн	
	б/т	%	б/т	%
1. Эвчин эмгэгээс шалтгаалсан хөдөлгөөний болон тулгуур эрхтний гэмтэл	0	0	3	0,57
2. Толгой , хүзүү, дунд шугамаас хазайсан дал, мөр, гуя тэгш биш	3	1.74	10	1.90
3. Цээжний хэлбэрийн өөрчлөлттэй (шуувун цээжтэй, хавтгай бортгон, юулгүүр цээжтэй)	28	16.28	132	25.09
4. Нурууны хэлбэрийн өөрчлөлттэй	58	33.72	258	49.05
5. Дал мэдэгдэхүйц унжсан	12	6.98	16	3.04
6. Гэдэс мэдэгдэхүйц цүдгэр	28	16.28	42	7.98
7. Хэлийн хэлбэрийн өөрчлөлттэй (Х,О маягийг майга)	36	20.93	52	9.88
8. Ердийн зогсолтын үед тавхай, өлмийн хэлбэр алдагдсан	4	2.32	1	0.19
9. Бүсэлхийн гурвалжин тэгш бус	2	1.16	8	1.52
10. Явах алхаад өөрчлөлттэй	1	0.58	4	0.76
ДҮН	172	100.0	526	100.0

НОМ ЗҮЙ

1. Белоусова А.З (1972) Руководство к практическим занятиям по гигиене детей и подростков. М. x 25-32
2. Варенич Е.И. (1974) К осанке сельских детей полесья. Гигиена и санитария, М x 95-96
3. Руководство для врачей школ Под.Ред. Г.Н.Сердюковской. М. (1983). x 74-76
4. Савельев .О.Н (1978) Состояние обмена фосфора у подростков со сколиотической осанкой. Гигиена и санитария, №6. x 49
5. Смоляр В.И. (1985) Гигиенические проблемы роста дет)й

и подростков. Киев. "Здоровье" x 92

6. Цолモン Ч (1994) Состояние здоровья школьников ряда регионов, Монголия с учетом факторов, его определяющих. Автореферат дисс. на соискание уч.ст.к.мн., х 6-7. 10-11, 17

ҮНДНЫ УСНЫ НАЙРЛАГА ДАХЬ БИОИДЭВХТ ЗАРИМ ЭЛЕМЕНТҮҮДИЙН АГУУЛАМЖИЙГ ХҮН АМЫН ХОЛБОГДОХ ӨВЧЛӨЛТЭЙ ХАРЬЦУУЛАН СУДЛАСАН ДҮН

Л.Нарантуяа, Ш.Энхцэцэг, Л.Пүрэвжав, Т.Тойвгоо,

Г.Туваанжав А.Батхишиг

Эрүүл Ахуй Халдварт Нян Судлалын Үндэсний Төв

Монголын байгал цаг уурын янз бүрийн бус нутгийн сум сууринд оршин суугчдын хэрэглэж байгаа үндны усны найрлагын үндсэн элементүүдийн агууламжийг хүн амын дунд тархмал байж болох зүрх судасны болон хоол боловсруулах, шээс ялгаруулах системийн зарим өвчний илрэлтийн байдалтай харьцуулан судлаж, үр дунг картограмм, циклограммын аргаар боловсруулах, эрүүл ахуйн үнэлгээ дүгнэлт өгөх зорилготой байв.

Судалгааны арга

Судлагаанд 1960-1992 онд ЭАХНСУИ, ЭАХС-ын байгууллагууд, Усны бодлогын хүрээлэнгийн лабораториудад хийсэн усны 14035 дээжийн 8 төрлийн, давтагдсан тоогоор 1090766 үзүүлэлт шинжилгээний дунг ашиглав. Улсын засаг зэхиргааны нэгжид хамаарах сум, суурин, аймгийн төвийг судалгааны нэгж объектоор сонгон авч холбогдох материалуудыг объект тус бүрээр нэгтгэн статистик аргаар боловсруулж, сум суурин, бусаар үр дунг 17 хүснэгт, 7 картограммаар харуулсны 9 хүснэгтийг сонгон авлаа.

Судалгааны дүн

Ерөнхий эрдэсжилтийн 80 орчим хувийг б төрлийн ион эзлэх бөгөөд тэдгээрийг усны найрлагыг тодорхойлогч үндсэн элементүүд гэнэ. Үнд катионаос натри, кальци, магни, анионоос хлорид, сульфат, гидрокарбонатын ионууд ордог. Эрүүл ахуйн талаас авч үзвэл тэдгээрийн дотроос кальци, магни, хлорид, сульфатын ионууд нь хүний амьдралд чухал үүрэгтэй биодэвхт элементүүд юм. Үүнээс үндэслэн судлагаанд үндны усны найрлага дахь кальци, магни, хлорид, сульфатын ионууд, катион,

анионы бүтэц, хатуулагийн нийт хэмжээ, ерөнхий эрдэсжилт гэсэн 8 үзүүлэлт, хүн амын дунд тохиолдож байгаа зүрхний ишеми (410-414), цусны даралт ихсэх (400-404), атеросклероз (440), тэдгээрийн илрэлтийн нийлбэр дүн, гастроудоценит (535), халдвартгүй гастроэнтерит, колит (561), цэс шээсний замын чулуужих ёвчнүүд (574, 592, 594), тэдгээрийн илрэлтийн нийлбэр дүн гэсэн 9 үзүүлэлт нийт 17 үзүүлэлтийг авч судлав.

ҮНДНЫ УСНЫ ҮНДСЭН НАЙРЛАГЫГ УЛСЫН ХЭМЖЭЭНД, СУМ, ГАЗАР ЗҮЙН БҮСЭЭР СУДЛАСАН ДҮН

Үндны усны үндсэн найрлагыг улсын хэмжээнд тогтоох судлагаанд сум, аймгийн төв бүгд 338 нэгж объект хамрагдсан. Нэгж объектод 7-50 удаагийн шинжилгээгээр ерөнхий эрдэсжилт, натри-кали, кальци, магни, хлорид, сульфат, гидрокарбонатын агууламжийг тодорхойлсон дүнг ашиглан катион, анионы бүтцээр нь яланг картоциклограмм боловсруулсан. Картоциклограмм нь тухайн аймгийн сумдад ямар ангилал төрлийн, ямар элемент давамгайлсан хэр зэрэг эрдэсжилттэй ус хүн амын хэрэгцээнд ашиглагдаж байгааг харуулна.

Хүн амын үнд ахуйд ашиглагдаж байгаа усны ерөнхий эрдэсжилтийн дундаж агууламжийг газар зүйн муж тус бүрээр нэгтгэн 1 дүгээр хүснэгтэд харуулав. Дорнодын талархаг мукийд хамаарах сум, суурингийн хүн ам хамгийн их эрдэсжилттэй ($1199,9 \pm 13,2$), Хангай-Хэнтийн уулархаг мукийд хамаарах сумдын хүн ам хамгийн бага эрдэсжилттэй ($491,3 \pm 1,5$) усиг хэрэглэж байна. Үнд ахуйн усны чанарыг ерөнхий эрдэсжилтээр УСТ-900-92-ын дагуу сум бүрээр авч үзвэл (2 дугаар хүснэгт) судлагдсан нийт сумдын 79.3%-д хүн ам эрдэсжилтээр хэвийн, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ус хэрэглэж байна. Харин Дорнодын талархаг мукийн сумдын 70.7%-д, Говийн мукийн сумдын 40.5%-д эрдэсжилт ихтэй, эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Үнд-ахуйн усны найрлага дахь кальцийн дундаж агууламжийг сум тус бүрээр гаргаж, тархалтыг улсын хэмжээнд харуулсан картограмм боловсруулах зорилгоор сумдыг үндны усных нь кальцийн агууламжаар 5 бүлэгт хувааж ангилав (3 дугаар хүснэгт). Үнд:

1 бүлэгт - 25.0 mg/dm^3 хүртэл кальци агуулсан буюу эрүүл ахуйн нормосс бага кальцитай ус хэрэглэгдэг.

2 бүлэгт - $51.0-75.0\text{ mg/dm}^3$

3 бүлэгт - $76.0-100.0\text{ mg/dm}^3$ хүртэл кальци агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирсон кальцитай ус хэрэглэдэг.

4 бүлэгт - 101.1 -зэс дээш кальци агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй, кальци ихтэй ус хэрэглэдэг сумдыг хамааруулав. Судлаачдын тогтоосноор хүн хоногт хэрэглэх кальцийнхаа 10-25%-ийг үндны уснаас авна. Судлагааны дунгээс авч үзвэл нийт сумдын 95%-д кальцийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон, харин 3.3%-д кальци багатай, 1.7%-д

кальци ихтэй, нийт 5%-д кальцийн агууламжаар хүн ам эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Үнд-ахуйн усны найрлага дахь магнийн дундаж агууламжийг сум тус бүрээр гаргаж, картограмм боловсруулах зорилгоор мөн сумыг үндны усных нь магнийн агууламжаар 5 бүлэгт ангилав.

(4 дүгээр хүснэгт). Үүнд:

1 бүлэгт - 10.0 мг/дм³ хүртэл магни агуулсан буюу эрүүл ахуйн нормоос бага магни агуулсан ус хэрэглэдэг

2 бүлэгт - 11.0-20.0 мг/дм³

3 бүлэгт - 21.0-30.0 мг/дм³ хүртэл тус тус магни агуулсан буюу магнийн агуулгаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон ус хэрэглэдэг

4 бүлэгт -31.0-40.0 мг/дм³-ээс их магни агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй магни ихтэй ус хэрэглэдэг сумдыг хамааруулав. Үндны усны магнийн агууламжийн доод хязгаар 10.0 мг/дм³-аас багагүй, дээд хязгаар 30.0 мг/дм³-ээс ихгүй байх шаардлагатай. Судлааганаас авч үзвэл нийт сумдын 61.0%-д хүн ам магнийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон усыг хэрэглэж байна. Харин 6.0%-д магни багатай, 33.0%-д магни ихтэй буюу нийт 39.0%-д хүн ам магнийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Хүн амын унд ахуйд ашиглагдаж байгаа усны ерөнхий эрдэсжилтийн дундаж агууламжийг газар зүйн муж тус бүрээр нэгтгэн 1 дүгээр хүснэгтэд харуулав. Дорнодын талархаг мужид хамаарах сүм, суурингийн хүн ам хамгийн их эрдэсжилттэй (1199.9 ± 13.2), Хангай-Хэнтийн улархаг мужид хамаарах сумд байна. Үнд ахуйн усны чанарыг ерөнхий эрдэсжилтээр УСТ-900-92-ын дагуу сум бүрээр авч үзвэл (2 дугаар хүснэгт) судлагдсан нийт сумдын 79.3%-д хүн ам эрдэсжилтээр хэвийн, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ус хэрэглэж байна. Харин Дорнодын талархаг мужийн сумдын 70.7%-д, Говийн мужийн сумдын 40.5%-д эрдэсжилт ихтэй, эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Үнд-ахуйн усны найрлага дахь кальцийн дундаж агууламжийг сум тус бүрээр гаргаж, тархалтыг улсын хэмжээнд харуулсан картограмм боловсруулах зорилгоор сумдыг үндны усных нь кальцийн агууламжаар 5 бүлэгт хувааж ангилав. (3 дугаар хүснэгт) Үүнд:

1 бүлэгт - 25.0 мг/дм³ хүртэл кальци агуулсан буюу эрүүл ахуйн нормоос бага кальцитийт ус хэрэглэдэг.

2 бүлэгт - 51.0-75.0 мг/дм³

3 бүлэгт- 76.0-100.0 мг/дм³ хүртэл кальци агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирсон кальцитай ус хэрэглэдэг.

4 бүлэгт - 101.1- ээс дээш кальци агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй, кальци ихтэй ус хэрэглэдэг сумдыг хамааруулав. Судлаачдын тогтоосноор хүн хоногт хэрэглэх кальцийнхаа 10-25%-ийг үндны уснаас авна. Судалгааны дунгээс

авч үзвэл нийт сумдын 95%-д кальцийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон, харин 3.3%-д кальци багатай, 1.7%-д кальци ихтэй, нийт 5%-д кальцийн агууламжаар хүн ам эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Үнд-ахуйн усны найрлага дахь магнийн дундаж агууламжийг сум тус бүрээр гаргаж, картограмм боловсруулах зорилгоор мөн сумдыг үндны усных нь магнийн агууламжаар 5 бүлэгт ангилав. (4 дүгээр хүснэгт). Үүнд:

1 бүлэгт - 10.0 мг/дм³ хүртэл магни агуулсан буюу эрүүл ахуйн нормоос бага магни агуулсан ус хэрэглэдэг.

2 бүлэгт - 11.0-20.0 мг/дм³

3 бүлэгт - 21.0-30.0 мг/дм³ хүртэл тус тус магни агуулсан буюу магнийн агуулгаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон ус хэрэглэдэг.

4 бүлэгт - 31.0-40.0 мг/дм³ хүртэл,

5 бүлэгт - 41.0 мг/дм³-ээс их магни агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй магни ихтэй ус хэрэглэдэг сумдыг хамааруулав. Үндны усны магнийн агууламжийн доод хязгаар 10.0 мг/дм³ -ээс багагүй, дээд хязгаар 30.0 мг/дм³-ээс ихгүй байх шаардлагатай. Судлагаанаас авч үзвэл нийт сумдын 61.0%-д хүн ам магнийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон усыг хэрэглэж байна. Харин 6.0%-д магни багатай, 330%-д магни ихтэй буюу нийт 39.0%-д хүн ам магнийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Үнд-ахуйн усны найрлага дахь хлоридын дундаж агууламжийг сум тус бүрээр гаргаж, картограмм боловсруулах зорилгоор сумдыг 5 бүлэгт ангилав. (5 дугаар хүснэгт) Үүнд:

1 бүлэгт - 150.0 мг/дм³ хүрэл

2 бүлэгт - 151.0-250.0 мг/дм³

3 бүлэгт - 251.0-350.0 мг/дм³ хүртэл тус тус хлорид агуулсан буюу хлоридын агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирсон ус хэрэглэдэг.

4 бүлэгт - 351.0-450.0 мг/дм³

5 бүлэгт - 451.0-ээс дээш хлорид агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй, хлорид ихтэй ус хэрэглэдэг сумдыг хамааруулав. Хлорид нь байгалийн ямар ч усанд байж болох бөгөөд амтлагдах хязгаар хүртэл хэмжээгээр агуулагдаж байхад хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй гэж үзнэ. Манай улсад үндны усны хлоридын агууламжийн зөвшөөрөгдхөд дээд хязгаарыг УСТ 900-92-д 350.0 мг/дм³-ээр тогтоосон байдаг. Судлагааны дүнгээс авч үзвэл нийт сумдын 94.7%-д хүн ам хлоридын агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Үнд-ахуйн усны найрлага дахь сульфатын дундаж агууламжийг сум тус бүрээр гаргаж, картограмм боловсруулах зорилгоор сумдыг 5 бүлэгт ангилав (6 дугаар хүснэгт) Үүнд:

1 бүлэгт - 125.0 мг/дм³

2 бүлэгт - 126.0-250 мг/дм³

3 бүлэгт - 251.0-375.0 мг/дм³

4 бүлэгт - 376.0-500.0 мг/дм³ хүртэл тус тус сульфат агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирсон ус хэрэглэдэг.

5 бүлэгт - 501.0 мг/дм³-ээс дээш судьфат агуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй сульфат ихтэй ус хэрэглэдэг сумдыг хамааруулав. Сульфат нь байгалийн усны эрдэс давсны үндсэн хэсэг бөгөөд амтлагдах хягаар хүртэл агуулагдаж байхад хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй байдаг. УСТ 900-92-д сульфатын зөвшөөрөгдөх дээд хязгаарыг 500.0 мг/дм³-ээс ихгүй байхаар тогтоожээ. Судлагааны дунгээс авч үзвэл нийт сумдын 96.7%-д хүн ам сульфат ихтэй эрүүл ахуйн шаардлагад тохирсон, 3.3%-д сульфат ихтэй эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

ҮНДНЫ УСНЫ ЭРДЭСЖИЛТИЙН ХЭЛБЭЛЗЛИЙГ ХҮН АМЫН ХОЛБОГДОХ ӨВЧЛӨЛТЭЙ ХАРЬЦУУЛАН СУДЛАСАН ДҮН

Хүн амын дунд тохиолдож байгаа зарим өвчний тархалтын судлагаанд сум, суурин, аймгийн төв нийт 335 нэгж объект хамрагдсан.

Үндны усны ерөнхий эрдэсжилтийн хэмжээ 100.0 мг/дм³-ээс багасах нь хүний биед ус давсны тэнцвэрт байдлыг алдагдуулна. Судлаачдын тогтоосноор үнлэны усны ерөнхий эрдэсжилт 200.0-400 мг/дм³ байх нь хамгийн тохиромжтой гэж үздэг. УСТ 900-92-д ерөнхий эрдэсжилтийн зөвшөөрөгдөх дээд хязгаарыг 1000.0 мг/дм³-ээс ихгүй байхаар тогтоожээ. Үндны усны эрдэсжилт хэт бага тохиолдолд хүн амын дунд жин буурах, булчин хатингарших, кальцийн дутагдал, бамбайн үйл ажиллагаа хямрах, зүрх судасны өвчнөөр нас барагт ихсэх зэрэг эмгэг байдлууд үүсдэг.

Хүний биед 1000.0-1500.0 гр кальци агуулагдах бөгөөд үүний 99.0% нь араг ясанд байдаг. Хэвийн нөхцөлд хүн хоногт 1.0 гр кальци хэрэглэх бөгөөд түүний 25-50% нь гэдсэнд шимэгдэнэ. Кальцийн биологийн ач холбогдлыг дараах байдлаар ойлгож болно. Үүнд: Кальци нь мэдрэл, булчингийн үйл ажиллагаанд оролцно. Булчингийн агшилтын үед кальци булчинийн ширхэгийн гадна байрладаг саркоплазмын тороос гарч суралтын үед эргэж орно. Кальци нь эсийн хуваагдах процесст сэдээгч нөлөө үзүүлнэ. Мөн ферментийн системд идэвхжүүлэх нөлөө үзүүлснээр эсийн мембранд нэвчиж, эсийн амьсгалах процесст оролцдог.

Кальцийн чөлөөт ионы хэмжээ ихсэхэд дараах эмгэгүүд илэрнэ. Үүнд: Бөөрний сувганцарт кальцийн давснууд тундасжиж, шээс үүсгэх ажиллагааг хямруулж ихээр шээлгэнэ. Мөн бөөрний чулуу үүсгэдэг. Мөн булчин сулрах, өтгөн хатах, рефлексүүд сулрах зэрэг мэдрэл булчингийн үйл ажиллагааны өөрчлөлт гарна. Кальци төв мэдрэлийн системд нөлөөлснөөс гутранга болох, дотор муухайрах, бөөлжүүлэх зэрэг шинж тэмдэг

илэрдэг. Тэрээр ходоодны шүүс ялгаруулалтыг ихэсгэнээс ходоодны хүчил ихэнэ.

Ходоодны шархлаа өвчнийг архаг гиперкальциемитэй холбоотой гэж зарим эрдэмтэд үздэг (Дж.Сильва, П.Р.Пэннелл). Кальци ихсэх нь зүрхний хэмийн алдагдлын хориг үүсгэх бөгөөд цусан дахь кальци 3.75 ммолъ/л-ээс ихэсвэл зүрх гэнэт зогсох аяултай.

Кальцийн ион дутагдахад татах рефлексүүд ихсэх, арьс, үс, хумус өөрчлөгдхөх, катарант үүсэх, зүрхний үйл ажиллагаа дутагдалд орох зэрэг шинж тэмдгүүд илэрнэ. Зөөлөн буюу кальци, магнийн агуулга баатай ус хэрэглэхэд хүний биед хүнд металлуудын үзүүлэх хорт нөлөөлөл нэмэгддэг.

Хүний биед 20-30 гр магни агуулагдана. Түүний 50% нь ясанд, үлдэх хэсгийн ихэнх нт эсийн дотор агуулагдана. Сийвэнд магни 0.5 ммолъ/л-ээс доош бол магнийн дутагдалд орно. Магнийн биологийн ач холбогдлыг дараах байдлаар илэрхийлж болох юм. Үүнд: магни нь зүрний булчингийн үйл ажиллагаанд агших, сурхах механизмд оролцено.(магни -АТФ) Мэн зүрхний эсүүдэд явагдах исэлдэх, нийлэгжих болон зөөвөрлөх процесст өрөлцено. (Г.Эххгорн, Peck, Ray). Английн эрдэмтдийн судласнаар зүрхний өвчнөөр нас барагчдын зүрхний булчинд агуулагдах хэмжээ 12-15% бага байжээ. (B.Chipperfield, Y.R.Chipperfield) Зөөлөн ус хэрэглэдэг хүмүүсийн зүрхний булчингийн эд эсэд агуулагдах магнийн хэмжээ хатуу ус хэрэглэдэг хүмүүсийнхээс 6%-иар бага байжээ. (Anderson ,бусад). Магни дутагдахад дүйнгэ, анивчих, хий үзэгдлийн байдалд орох, чичрэх, татах, мэдээ муудах, зүрхний цохилт олшорох зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Магнийн дутагдал нь кальцийн дутагдалтай хавсран тохиолдож болдог. Үндны усны найрлага дахь кальци, магнийн нийлбэр хэмжээг мг-экв/дм-ээр илэрхийлснийг хатуулагийн нийт хэмжээ гэдэг. Хатуулагийн нийт хэмжээнд магни 30%-иас хэтрэхгүй байх шаардлагатай.Хатуулагийн нийт хэмжээ ихсэх нь берилии,бор, кадми, кали, натри зэрэг 12 элементийн хэмжээг нэмэгдүүлэх нелөөтэй байдаг. Хатуулаг ихтэй ус хэрэглэдэг хүмүүсийн дунд бөөр, шээсний замын чулуужих өвчин нутагшмал хэлбэрээр тохиолддог болохыг судлаачид тогтоожээ. Хүн хоногт хэрэглэх байгаа хоол хүнсний бүтээгдэхүүнээс хангалттай хэмжээгээр магни авч чаддаггүй. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах магнийн дөнгөж 30% биед шингэдэг. Харин үндны усан дахь кальци, магни нь ууссан ионы хэлбэрээр байх учраас 100% шингэдэг. (Nordin et all) Хоол хүнсэнд агуулагдах фитат, аминхүчлүүд зэрэг органик бодисууд нь магни болон бусад элементүүдтэй нэгдэж тэдгээрийн шингэцийг бууруулна. Мэн магни, фосфор хүчлийн болон нүүрсхүчлийн давсуудтай нэгдэж усанд муу уусдаг нэгдлүүд үүсгэнэ. Хоол хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах явцад магни алдагдана. Тухайлбал хоолыг чанаход (хүнсний ногоог) 67%, хөлдөөхөд 28-30%-иар магни алдана ("Хроника ВОЗ" 1979).

Үндны усны ерөнхий эрдэсжилтийн хэмжээ ихсэх нь ходоодны үйл ажиллагаанд нэлөөлж шүүс ялгаралтыг ихэсгэх ба ус давсны тэнцвэрийг алдагдуулна. Мөн билемхбодод явагдах биохимиийн болон метаболийн процесст эмгэгээр нэлөөлэх ба цангалтыг ихэсгэнэ. Ялангуяа сульфатын агууламж ихсэх нь гүйлгэх, туулгах нэлөөлэлийг үзүүлдэг. Эдгээрээс үндэслэн бид судлагаандаа хун амын дунд нэлээд тархмал хэлбэрээр тохиолдог зарим өвчний сонгон авч өвчлөлийн сүүлийн 10 жилийн дунг картограммаар харуулсан.

1. Зүрх судасны өвчнөөс зүрхний ишеми, цусны даралт ихсэх, атеросклероз (400-404, 410, 414, 440)-ыг сонгон авч тэдгээрийн нийлбэр дунг тухайн газар зүйн бүсэд хамаарах сум бүрээр тооцож картограммд оруулахын тулд сумдыг өвчний илрэлтийн нийлбэр дунгээр 5 бүлэгт ангилав (7 дугаар хүснэгт).

Зүрх судасны өвчний илрэлтийн нийлбэр дунгээр

1 бүлэгт - 10000 хүн амд 50 хүртэл

2 бүлэгт - 10000 хүн амд 51-100 хүртэл

3 бүлэгт - 10000 хүн амд 101-200 хүртэл

4 бүлэгт - 10000 хүн амд 201-300 хүртэл

5 бүлэгт - 10000 хүн амд 301-ээс дээш өвчлөлтэй сумдыг хамааруулав. Судлагдсан зүрх судасны өвчний илрэлтийн нийлбэр дунгийн улсын дундаж 10000 хүн амд харьцуулснаар 100.4-4.29 байлаа. Судлагаанаас авч үзвэл нийт сумдын 64.8%-д эдгээр өвчин 10000 хүн амд харьцуулснаар 100 хүртэл 35.2%-д 101-ээс дээш тохиолдож байна. Сонгож авсан зүрх судасны эдгээр өвчний хамааралтай эсэхийг корреляцийн коэффициентийг үнэлэх Пирсоны аргаар тооцоход дунд зэргийн урвуу (ху=-0.6) хамааралтай байлаа.

2. Судлагаанд хоол боловсруулах ба шээс ялгаруулах системийн өвчнүүдээс гастроудоденит, халдвартгүй гастрозентерит, колит, цөс, шээсний замын чулуужих өвчнүүд (535, 561, 574, 592, 594)-ийг сонгон авч тэдгээрийн нийлбэр дунг сум бүрээр нэгтгэн картограммд оруулах зорилгоор сумдыг өвчний илрэлтийн нийлбэр дунгээр мөн 5 ангилав (8 дугаар хүснэгт). Хоол боловсруулах болон шээс ялгаруулах системийн өвчний илрэлтийн нийлбэр дун

1 бүлэгт - 10000 хүн амд 100 хүртэл

2 бүлэгт - 10000 хүн амд 101-200 хүртэл

3 бүлэгт - 10000 хүн амд 201-300 хүртэл

4 бүлэгт - 10000 хүн амд 301-600 хүртэл

5 бүлэгт - 10000 хүн амд 601-ээс дээш өвчлөлтэй сумдыг хамааруулав. Судлагаанаас авч үзвэл сонгож авсан хоол боловсруулах болон шээс ялгаруулах системийн өвчнүүдийн илрэлтийн улсын дундаж 10000 хүн амд харьцуулснаар 244.1 ± 10.6 байна. Нийт сумдын 77.6%-д эдгээр өвчин 10000 хүн амд 300 хүртэл, 22.4%-д 301-ээс дээш тохиолдож байна. Судлагдсан хоол боловсруулах болон шээс ялгаруулах системийн өвчний илрэлтийн нийлбэр дунг үндны усны ерөнхий эрдэсжилтийн

ихсэлттэй хамааралтай эсэхийг корреляцийн коэффициентийг үндэлж Пирсоны аргаар тооцоход сул шууд хамааралтай (ху-0.12) байлаа..

Үндны усны үндсэн найрлагыг тодорхойлогч б элементийн агууламж Сумдын эрүүл ахуйн шаардлага хангах байдлын хамаарлыг 9 дүгээр хүснэгтээр харуулав. Судлагаанаас авч үзвэл нийт сумдын 38.5%-д хүн ам эрүүл ахуйн шаардлагад (1*6 үзүүлэлтээр) тохирохгүй ус хэрэглэж байна. Үүнийг газар зүйн бүсээр авч үзвэл Дорнодын талархаг мужид хамаарах сумдын (41) 70.7%-д (29 сум) 1-5 үзүүлэлтээр , Говийн мужид хамаарах сумдын (74) 67.6%-д (50 сум), 1-6 үзүүлэлтээр, Алтайн уулархаг мужид хамаарах сумдын (47) 42.5%-д (20 сум) 1-4 үзүүлэлтээр , Хангай-Хэнтийн уулархаг мужид хамаарах сумдын (176) 17.6%д (31 сум) 1-2 үзүүлэлтээр тус тус хүн ам эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

Энэхүү судлагааны ажлын үр дүн нь анагаах ухаан, ус судлал, усан хангамжийн технологийг боловсронгуй болгох чиглэлээр судлагаа шинжилгээний ажлыг эрхлэн гүйцэтгэдэг болон сум орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд практикийн чухал ач холбогдолтой мэдээлэл юм.

ДҮГНЭЛТ

1. Монгол улсын хэмжээнд нийт сумдын 38.5%-д хүн ам үндны усны үндсэн найрлагын нэг буюу хэд хэдэн үзүүлэлтээр эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус хэрэглэж байна.

2. Улсын хэмжээнд нийт сумдын 32.5%-д зүрх судасны зарим өвчинүүдийн (400-404, 410-414, 440) илрэлт сүүлийн 10 жилийн (1980-1989 он) дундаж 10000 хүн амд харьцуулснаар 101-ээс дээш тохиолдож байна.

3. Улсын хэмжээнд нийт сумдын 22.4%-д хоол боловсруулах болон шээс ялгаруулах системийн өвчинүүдийн (535, 561, 574, 592, 594) илрэлт сүүлийн 10 жилийн дундаж 10000 хүн амд харьцуулснаар 301-ээс дээш тохиолдож байна.

4. Зүрх судасны зарим өвчинүүдийн илрэлт нь үндны усны ерөнхий эрдэсжилтийн ихсэлттэй дунд зэргийн урвуу (ху—0.6) хамааралтай байна.

5. Хоол боловсруулах болон шээс ялгаруулах системийн зарим өвчинүүдийн илрэлт нь үндны усны ерөнхий эрдэсжилтийн ихсэлттэй шууд сул (ху-0.12) хамааралтай байна.

Дээрхи дүгнэлтээс үндэслэн:

1.Улсын хэмжээнд ерөнхий эрдэсжилт, магнийн агууламжаар эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй устай сумдын усны чанарыг сайжруулах технологийн асуудлыг шийдвэрлэх

2. Үндны устай холбоотой өвчлөлийг тодорхой бус нутагт гүнзгийрүүлэн судлах нь нутагшмал зарим өвчинөөс урьдчилан сэргийлэх нийтийг хамарсан арга хэмжээний үндэслэлийг

боловсруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтойг холбогдох байгуулагуудад зөвлөж байна.

НОМ ЗҮЙ

1. Казначев В.П (1989) Учение о биосфере - М: Знание 80с
2. Войткевич Г.В. (1984) Геологическая хронология земли - М: Наука 128с
3. Перельман А.И (1982) Геохимия природных вод -М: Наука 154 с
4. Новиков Ю.В., Сайфутдинов М.М., (1981) Вода и жизнь на Земле - М: Наука 184с
5. Пиннекер Е.В. (1984) Подземная гидросфера - Новосибирская Наука 154с
6. Үндны ус Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт (УСТ-900-92)
7. Коммунальная гигиена (Авт.К.И.Акулов, К.А.Буштуева, Е.И.Гончарук и др) Под ред.К.И.Акулова, К.А.Буштуевой.- М: Медицина (1986) с 32-256
8. Эпидемиология неинфекционных заболеваний (Под.ред А.В.Вихерта А.В.Чаклина) АМН СССР- М Медицина (1990). с 3-92
9. Зильва Дж.Ф., Пеннелл П.Р (1988) Клиническая химия в диагностике и лечение. Пер. с англ. М.Медицина, с 18-101
10. Шошин А.А (1964) Военно-медицинская география Л: Воен:изд., с 7-48
11. Салищев К.А Картография :(1982) Учебник для географических специальностей ун.тов 3-е изд.перераб. и доп. М. Высш.школа. 272с

Хүснэгт №1

ХҮН АМЫН ҮНД АХУЙД АШИГЛАГДАЖ БАЙГАА УСНЫ ЕРӨНХИЙ ЭРДЭСЖИЛТИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ (мг/дм3-ээр)

	Бүсийн нэр	Сумын тоо	Дээжи тоо	эрдэсжилт, мг/дм3-ээр		
				дун-даж	ха-зайлт	ал-даа
1	Хангайн Хэнтийн уулархаг муж	176	2902	491.3	80.8	1.5
2	Алтайн уулархаг муж	47	597	656.1	299.8	12.3
3	Дорнодын талархаг муж	41	961	1199.9	410.0	13.2
4	Говийн муж	74	1694	1083.8	258.8	5.8
Улсын хэмжээнд		338	6154	781	306.2	3.9

Хүснэгт №2
ЕРӨНХИЙ ЭРДЭСЖИЛТЭЭР УНД АХҮЙН УСНЫ ЧАНАРЫГ ҮНЭЛСЭН ДҮН

	Бусийн нэр	Сумын тоо	Тохирсон		Эрүүл ахуйн нормд тохигоогүй		ИХ	
			тоо	%	тоо	%		
1	Хангай Хэнтийн уулархаг муж	176	168	95.5	2	1.1	6	3.4
2	Алтайн уулархаг муж	47	44	93.6	-	-	3	6.4
3	Дорнодын талархаг муж	41	12	29.3	-	-	29	70.7
4	Говийн муж	74	44	59.5	-	-	30	40.5
	УЛСЫН ХЭМЖЭЭНД	338	268	79.3	2	0.6	68	20.1

**Хүснэгт №3
СУМДЫН ҮНД-АХУЙН УСНЫ КАЛЬЦИЙН АГУУЛАМЖИЙГ БҮЛЭГЛЭСЭН БАЙДАЛ**

		Агуулагдх хэмжээ, мг/дм ³ -ээр			
Үзүүлэлт	Бугд	Нормоос бага	Нормын хязгаарт, 25.0-100.0	Нормоос их	
		25.0 хүртэл	26.0-50.0	51.0-75.0	76.0-100.0
Сум, сууринны тоо	338	11	176	111	34
Эзлэх хувь	100	3.3	52.0	33.0	10.0
Тайлбар: Үнд-ахуйн усны найрлага дахь кальцийн агууламжийн улсын дундаж 54.6 мг/дм ³ байна.			95.0		1.7

**Хүснэгт №4
СУМДЫН ҮНД-АХУЙН УСНЫ НАЙРЛАГА ДАХЬ МАГНИЙН АГУУЛАМЖИЙГ БҮЛЭГЛЭСЭН БАЙДАЛ**

		Агуулагдх хэмжээ, мг/дм ³ -ээр			
Үзүүлэлт	Бугд	Нормоос бага	Нормын хязгаарт, 11.0-30.0	Нормоос их	
		10.0 хүртэл	11.0-20.0	21.0-30.0	31.0-40.0
Сум, сууринны тоо	338	20	115	91	47
Эзлэх хувь	100	6.0	34.0	27.0	14.0
Тайлбар: Үнд-ахуйн усны найрлага дахь магниийн агууламжийн улсын дундаж 28.5 мг/дм ³ байна.					19.0

Хүснэгт №5

СУМДЫН ҮНД-АХҮЙН УСНЫ ХЛОРИДИЙН АГУУЛАМЖИЙГ БҮЛЭГЛЭСЭН БАЙДАЛ

Үзүүлэлт	Бүгд	Агуулагдах хэмжээ, мг/дм ³ -ээр			
		Нормын хязгаарт, 350.0 хүртэл			
	150.0 хүртэл	151.0-250.0	251.0-350.0	351.0-450.0	451.0-ээс дээш
Сум, сүүрины тоо	338	265	39	16	8
Эзлэх хувь	100	78.9	11.2	4.6	2.4
Тайлбар: Үнд-ахуйн усны найрлага дахь хлоридийн агууламжийн улсын дундаж 102.9 мг/дм ² байна.		94.7			

24

ХУСНЭГТ №6
СУМДЫН ҮНД-АХҮЙН УСНЫ СУЛЬФАТЫН АГУУЛАМЖИЙГ БҮЛЭГЛЭСЭН БАЙДАЛ

Үзүүлэлт	Бүгд	Агуулагдах хэмжээ, мг/дм ³ -ээр			
		Нормын хязгаарт, 500.0 хүртэл			
	125.0 хүртэл	126.0-250.0	251.0-375.0	376.0-500.0	501-ээс дээш
Сум, сүүрины тоо	338	194	85	38	10
Эзлэх хувь	100	57.4	25.1	11.2	2.9
Тайлбар: Үнд-ахуйн усны найрлага дахь катионийн агууламжийн улсын дундаж 146.8 мг/дм ³ байна.		96.7			

ХУСНАГТ №7
ХҮН АМЫН ЗУРХ СУДАСНЫ СИСТЕМИЙН ЗАРИМ ОВЧНИЙ (400-404,410-414, 440)
ИЛРЭЛТИЙН ДУНДАЖИЙГ СУМДААР

Үзүүлэлт	Бүгд	Булэгтэл 10000 хүн амд харьцуулнаар				
		I	II	III	IV	V
	50 хүргэл	51.0-100.0	101.0-200.0	201.0-300.0	301.0-ээс дээш	301.0-ээс дээш
Сум, сурини тоо	336	88	129	85	24	9
Эзлэх хувь	100	26.3	38.5	25.4	7.1	2.7
Тайлбар: Дээрх овчний илрэлтийн улсын дундаж 10000 хүн амд харьцуулнаар 100.4±4.29 байв.		64.8			35.2	

ХУСНАГТ №8
ХҮН АМЫН ХООЛ БОЛОВСРУУЛАХ БОЛОН ШЭЭС ЯЛГАРУУЛАХ СИСТЕМИЙН ЗАРИМ
ОВЧНИЙ (535,564,574,592,594) ИЛРЭЛТИЙН ДУНДАЖИЙГ СУМДААР БУЛЭГЛЭСЭН
БАЙДАЛ (1980-1989 он)

Үзүүлэлт	Бүгд	Булэгтэл 10000 хүн амд харьцуулнаар				
		I	II	III	IV	V
	100.0 хүргэл	101.0-200.0	201.0-300.0	301.0-600.0	601.0-ээс дээш	601.0-ээс дээш
Сум, сурини тоо	335	61	108	91	57	18
Эзлэх хувь	100	18.2	32.2	27.2	17.0	5.4
Тайлбар: Дээрх овчний илрэлтийн улсын дундаж 10000 хүн амд харьцуулнаар 24.4±10.6 байв.		77.6			22.4	

Хүснэгт №9
ҮНДНЫ УСНЫ ҮНДСЭН НАЙРЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ЭРҮҮЛ
АХУЙН ШААРДЛАГАД ТОХИРОХГҮЙ УСТАЙ СҮМДЫН
СУДАЛГАА

Мужийн нэр	бүгд	хувь	Сумд үзүүлэлтийн тоогоор					
			1	2	3	4	5	6
1.Хангай-Хэнтийн уулархаг	31	17.6	27	4				
2. Алтайн уулархаг	20	42.5	12	6	1	1		
3. Дорнодын талархаг	29	70.7	7	19	1	1	1	
4. Говийн	50	67.6	25	9	8	4	3	1
Улсын хэмжээнд эзлэх хувь	130	38.5	71 21.	38 11.	10 3.0	6 1.8	4 1.2	1 0.3

МОНГОЛ ОРНЫ ТАРВАГАН ТАХЛЫН ДЭГДЭЛТҮҮДЭД БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨГ СУДАЛСАН ДҮН

Л.Энхбаатар, Л.Лхагва

Эрүүл Ахуй, Халдварт Нян судлалын Үндэсний Төв, Анаагаах

Ухааны Их Сургууль

Манай улсад сүүлийн 30 жил тарваган тахал өвчин харьцангуйгаар тасралтгүй өссөнөөс Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий зэрэг аймгийн тарваган тахалын байгалийн голомтууд идэвхжиж голомт нэмэгдэн өвчилсөн хүмүүсийн 33-40% нь нас баржээ.

Зөвхөн сүүлийн 13 жилд 53 дэгдэлтэнд 101 хүн, үүнээс 1993 онд 12 дэгдэлтэнд 13 хүн өвчилснээс 8 хүн нас барсны 66.7% нь 9-15 насны хүүхэд, 38% нь амьсгалын замаар, 62% нь хавьтлын замаар уг өвчинийг авчээ. Сүүлийн 13 жилд 1956-1979 оныхтой харьцуулахад дэгдэлт 17.1%, өвчлөл 91.8% өсчээ. (1)

Халдварт өвчиний цар тахал, үүнээс тарваган тахлын байгалийн голомт идэвхжих механизмыг эрдэмтэд олон янзаар тайлбарласнаас мэрэгчид нууц ба архаг байдлаар нян хадгалах ба бусад учир шалтгаанууд нь олон тооны агуулагч, дамжуулагч, газар нутгийг богино хугацаанд хамрах нөхцөлийг бурддүүлж чаддаггүй гэж үздэг. Эдгээр онол таамаглалуудаас Оросын биофизикч А.Л.Чижевскийн нарны идэвхжил (НИ)-ийн өөрчлөлт дэлжийн шим мандал, билемхбодод нөлөөлөх онол сонирхол татаж байна.(2)




График №1
Монгол орон дахь тарваган тахлын дэгдэлт сүүлийн 75 жилд

Судалгааны арга хэрэглэгдэхүүн

Судалгаанд Монгол улсад 1880 оноос хойш БГХАЭСГ-н түүхэнд тэмдэглэгдсэн 115 жилийн хугацаан дахь бүрэн бус 287 илүү тахлын гаралтыг Австрийн одон орны оргил судлалын төвөөс гаргасан НИ-н Вольфын тоон утгатай ретроспектив, түүхэн адилтгалын аргаар харьцуулан судлав.

Судалгааны үр дүн хэлцэмж:

Судалгаагаар тус улсад уг хугацаанд тарваган тахлын 4 томоохон дэгдэлт болсон гэж үзэв.

(График№1)

1-р дэгдэлтийн оргил үе 1899 он

2-р дэгдэлтийн оргил үе 1928 он

3-р дэгдэлтийн оргил үе 1949 он


4-р дэгдэлтийн оргил үе 1993 он

Эдгээр оргил үеүд нь тухайн цаг хугацаа орон зайд дэгдэлт, өвчилсөн хүний тоогоор хамгийн өндөр байсан болно.

Тухайлбал: 1-р дэгдэлтийн оргил үе: 1899 онд одоогийн Төв аймгийн Дэлгэрхан сумын нутагт Хятад, Монгол лам иргэд хамрагдсан 300 хүн, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын өмнөт хэсэгт дэгдэлт, Дорнот аймгийн Чойбалсан сумын баруун суврагт 80 орчим хүн өвчилсөн дэгдэлтүүд гарчээ.(3)

2-р дэгдэлтийн оргил үе: 1928 онд тал, хээр, ойт хээрийн бүсийн Дорнот, Дундговь, Төв, Өвөрхангай,Хэнтий зэрэг аймагт нийт 10 дэгдэлтэнд 37 хүн, 1931 онд Сүхбаатар, Дундговь, Хэнтий аймагт нийт 11 дэгдэлтэнд 23 хүн өвчилж байсан байна. (4)

3-р дэгдэлтийн оргил үе: 1940-1950 оны дунд үе хүртэл тахлын голомтууд идэвхжиж олон дэгдэлт гарснаас 1949 он оргил үе нь байв. Энэ дэгдэлтүүд Монголын зүүн хэсгээс баруун хэсэгт



Зураг №1

Тарваган тахлын байгалийн голомтын идэвхжилт, дэлгөөнжилт (1920-1995 он)

шилжсэн гэж үзэж болохоор байна. (5) Зөвхөн 1949 онд 23 дэгдэлтэнд 37 хүн өвчилж дэгдэлтүүд Говь-Алтай, Баянхонгор, Завхан аймгийн нутаг Хангай, Алтайн нуруунд болжээ.

4-р дэгдэлтийн оргил ўе: 1993 он сүүлийн 30 жилд тохиолдож байгаагүй олон дэгдэлт болжээ. Дэгдэлтүүд Өвөрхангай, Хэнтий, Баян-Өлгий, Завхан, Ховд, Говь-Алтай аймгийг хамарч нийт 12 дэгдэлтэнд 13 хүн өвчилсөн байна. Томоохон дэгдэлтүүдийн хоорондын зайд 1899-1928 он 29 жил, 1928-1949 онд 21 жил, 1949-1993 он 44 жил дунджаар (31.3-34.3)=33 жил болж байна. Судалгаанд хамрагдсан 11 жилд 21; 33; 44 жилийн хэмнэлээс гадна богино, дунд хэмнэл илрэв.

Богино хэмнэл: 113 жилд тодорхой хугацаанд харьцангуй ихэссэн дэгдэлтүүд 23 удаа тохиолдсон байна. Эдгээр онууд 1880, 1886, 1899, 1905, 1912, 1918, 1922, 1926, 1931, 1938, 1940, 1942, 1945, 1949, 1952, 1961, 1964, 1967, 1970, 1973, 1983, 1986, 1990, 1993 дунджаар 3.9-4.9 жил тутамд ямар нэг хэмжээгээр дэгдэлт гарч байжээ.

Дунд хэмнэл: Дэгдэлтүүд богино хэмнэлийнхээс харьцангуй өндөр, мэдэгдэхүйц ихэссэн дэгдэлтүүдийн хоорондын зайл авав. Дунд хэмнэлийн харьцангуй ихсэлтүүд 115 жилд ойролцоогоор 12 удаа тохиолджээ. 1880, 1886, 1899, 1905, 1912, 1918, 1928, 1942, 1949, 1964, 1973, 1983, 1993 он дунд хэмнэлийн үргэлжлэх хугацаа дунджаар 9.4 жил байна. Дунд хэмнэл сүүлийн 45 жилд (1949-1994 он) тод илрэчээ.

Тухайлбал 1949, 1964, 1973, 1983, 1993 он харьцангуй ихсэлт дэгдэлтүүд дунджаар 11.5 жил тутамд 1949 оныг эс тооцвол НИ-н уруудах, нам үед тогтвортой тохиож байв.

Оросын эрдэмтэн А.Л.Лавровскийн үзсэнээр тарваган тахлын томоохон эпизоотиуд 10-11, завсрынх 4-5 жилийн зайтай гардаг гэж үзсэн байна. (6)

Монгол орны тарваган тахлын байгалийн голомтонд шилжилт идэвхжлийг тодорхойлох зорилгоор 1920-1995 оны хоорондох




График №2

хугацаанд аймгуудыг уртрагийн дагуу үечлэн дэгдэлтүүдэд ажиглалт хийв. (Зураг №1) Тахлын дэгдэлтүүд газар зүйн байрлалаар ялгаатай идэвхжиж, дөлгөөнжиж буй байдал ажиглагдаж байна.

1. 1918-1934 онд харьцангуй дөлгөөн, Монгол орны дорнот хэсэг идэвхтэй байжээ.

2. 1934-1957 оны хооронд Хангай, Говь-Алтайд голомт идэхтэй, зүүн хэсэг харьцангуй намжмал, Монгол оронд хур тунадас бага гандуу өвчлөл, дэгдэлт их байв. (График №2)

3. 1976 оноос хойш Монгол орны баруун хэсэг Алтай, Хангайн нурууны голомтууд идэвхжсэн бөгөөд хамгийн өндөр дэгдэлтэй жил 1993 он болжээ. Монгол оронд тарваган тахлын харьцангуй идэвхтэй үеийн хугацаа ерөнхийдөө 23 оргим жил гэж үзэж болохоор байна.

Манай оронд явагдсан нийт тахлын дэгдэлтүүдийг НИ-тэй холбон судлахдаа уг өвчин лабораторийн шинжилгээгэр батлагдаж ирсэн 1931 оноос авч үзлээ.

Дэгдэлтүүдийн НИ-н зерэг, сөрөг мөчлөг түүний өндөр, нам үе дэхь тохиолт нь түүний богино, дунд, их хэмнэлийн далайцтай тодорхой хэмжээгэр тохирч байна. 22-44 жилийн их хэмнэлийн оргил үе НИ-н зерэг, мөчлөгийн өндөр үетэй, сүүлийн 30-45 жилийн дэгдэлтүүдийн оргил үе дунджаар 9.4-11.5 (10.4) жилийн хэмнэлтэй идэвхжлийн нам, уруудах үед тохирч байна.

Тахлын дэгдэлтүүдийн 10.4, 21, 23, 44 жилийн хэмнэл нь НИ-н 11, 22, 33, 44 жилийн хугацаатай дүйж байна. Дэлхий нийтэд тохиолдож байсан цар тахал дэгдэлтүүдийн 65% нь өндөр, 35% нь нам үед, газар зүйн байршилаас шалтгаалан Энэтхэгт өндөр үед гарч байжээ. (7)




График №3

Монгол орон дахь үлийн цагаан оготны ихсэлт ба нарны идэвхжил

Тус орны тарваган тахлын байгалийн голомтуудад цаг агаар, чийг хур тундасны нөлөөг зөвлөлтийн болон үндэсний мэргэжилтнүүд бичиж байв. Тухайлбал: 40-50 оны үед Хангай нурууны тарваган тахлын байгалийн голомтонд 1941, 1944, 1947, 1951, 1953 оны ган нөлөөлж хур тундас 45 мм-ээс бага үед ургамлын гарц, тарваганы амьдралд сөрөг нөлөөлдөг. (8)

Дорнот Монголын тарваган тахлын байгалийн голомтын эпизоотид цаг агаарын нөлөөллийг 1981 онд (9), Монгол Алтайн зүүн өмнөд бүсийн тарваган тахлын 9 голомтонд сүүлийн 49 жилд дунджаар 11.3 жил үргэлжилж 13.6 жилийн завсралагатай 22.9 жилийн үечлэлтэй хур тунадастай холбоотой (1) байжээ.

Гурван сайхан огдоин голомтын халдважилт, өсгөвөр илрэлт нарны идэвхжлийн уруудах үед өндөр байна гэж үзжээ. (10)

Газар зүйч Б.Авирамэд, П.Цолмон нарны судалгаагаар XVIII-XX зууны гангижийн тохиолдол НИ-н бага үед зэрэг мөчлөгийн уруудах үед их байгааг тэмдэглэсэн ба цаг уурч А.Намхайн судалгаагаар ган, зудын давтамж 6.10-12.45 жилийн давтамжтай явагдаж буйг тогтоосон байна. (11,12) Манай орны байгаль газар зүйн нөхцөлд хоол боловсруулах, амьсгал, зооантроноз малын зарим халдварт өвчний ихсэлтэнд НИ-л нөлөөлж хэмнэлт явцтай байгааг тэмдэглэжээ. (13,14,15,16)

Эрдэмтдийн судалгаагаар тарваган тахлын нянг агуулагч мэрэгчдийн тоо толгой, НИ-н тодорхой үед ихсэдэг байна. (17) Манай орны тарваган тахлын үндсэн агуулагч тарваганы тоо толгойд НИ-н нөлөөг судлаагүй боловч тахлын нян агуулагч үлийн цагаан оготнын хэт олшролтонд НИ-н нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Судлаачдын тэмдэглэснээр манай оронд 1926-1929 онд, 1941-1943, 1956-1957, 1963—1965, 1970-1973, 1980-1985 онуудад

үлийн цагаан оготно хэт ихэссэн байна. Ихсэлтуудийн оргил үе 1926, 1943, 1956, 1964, 1973 онуудад тохиож зарим тохиолдолд ургамлын нэмрөгийн 90%-ийг хөнөөж байв. (18)

Үг мэрэгчийн хэт олшролт, оргил үеүдийг НИ-тэй холбон авч үзэхэд нийт ихсэлтийн 50-66% нь НИ-н нам, уруудах үед 11,7 жил тутамд ихсэж байв. Ихсэлтууд дунджаар 2.6 жил үргэлжилж байна. (График №3)

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан хугацаанд тус улсад 4 томоохон дэгдэлт явагдсан байна. Голомтын идэвхжил эзүнээс баруун тийш чиглэлтэй одоогийн байдаар идэвхжил Монгол орны баруун хэсэгт явагдаж байна.

2. Тарваган тахлын байгалийн голомтын идэвхжил 4,9,10,5,22,33,44 жил тутамд идэвхжиж энэ нь байгалийн хэлбэлзэл НИ-н соронзон орны нөлөө гэж үзэв.

3. Тарваган тахлын 22-44 жилийн томоохон дэгдэлтуудийн оргил үе НИ-н өндөр үед, 9,5-11 жилийн хэмнэл НИ-н нам, уруудах үед явагдаж байна. 1993 онд Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Завхан зэрэг аймагт гарсан 12 дэгдэлт нь тарваган тахлын байгалийн голомтын 44 жилийн хэмнэл идэвхжлийн оргил үе гэсэн дүгнэлтэд хурэв.

4. Тарваган тахлын агуулагч үлийн цагаан оготно 11,7 жил тутамд НИ-н нам үед хэт олширч буйг тогтоов. Үүнээс үндэслэн үндсэн агуулагч тарваганы ихсэлтийг байгалийн голомт тус бүрээр тогтоож уг өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх практикт ач холбогдолтой юм.

5. Монгол орны тарваган тахлын байгалийн голомтын идэвхжил 2000 он гартал аажим буурах боловч жил, жилд тахал гарах боломжтой гэж үзэв.

НОМ ЗҮЙ

1. Адъяасурэн.З., (1994) "Эпидемический потенциал природных очагов чумы юго-восточной части Монгольского Алтая" автореферат на соискание ученой степени кандидата медицинских наук УБ 32 с.

2. Ягодинский И.В., (1987) "Александр Леонидович Чижевский" Москва "Наука" с. 85-99

3. Бердин.А.Л., (1933) Чума в МНР тарбаган промысел" Эдүгээгийн Монгол №2 50 с.

4. Ц.Чулуунбаатар ба бусад (1985) ГАХӨЭСГ-ын түүх

5. Батсүх.Д., Цолмон.П., Энхбаатар.Л., (1990) "Тарваган тахлын тархалтын зүй тогтлын асуудал" ГАХӨЭСГ-н бүтээл №6

УБ хот

6. Дружинин И.П., Сазанов .Б.И., Ягодинский.И.В., (1974) Космос, земля, прогноз, Москва
7. Чижевский.А.Л., (1973) "Земное эхо солнечных бурь" с.181-185
8. Некипелов.Н.В., (1959) "Чуме в Монголии" г.Иркутск.
9. Батсүх.Д., (1981) "Природные очаги чумы в восточной части МНР" Авторефрат диссертации на соискание ученой степени кандидата медицинских наук г.УБ 25 с.
- 10: Энхбаатар.Л., Батсүх.Д., (1990) Гурван сайхны тарваган тахлын байгальн голомтын дамжуулагчийн тоошилд хур тунадасны нелее ГАХӨЭСГ мэдээлэл №6
11. Авирамэд .Б ба бусад (1993) Монгол орны хүн, малын зарим өвчин эмгэгийн хөдлөл зүй тавилан товхимол 6-11х УБ
12. Намхай.А., (1988) "Байгаль цаг уурын гамшигт үзэгдэл" МЭДН, байгалийн ухааны цуврал лекц 12 4х.
13. Энхбаатар.Л., (1995) "Зарим халдварт өвчиний хэмнэлийг тодорхойлсон дүнгээс Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал цаашдын зорилт ОПБХИ-н хураангуй х. 50-51, УБ хот.
14. Enkhbaatar. L., (1995) Influence of solar activity on infectious disease morbidity in Mongolia and it's peculiarity. "International conference Asian ecosystems and their protection" Ulaanbaatar Mongolia p 113
15. Энхбаатар.Л., Дондог.Н., Цолмон.П., (1992) Хүн, малын галзуу өвчний байгалийн хэлбэлзэлт хүчин зүйлтэй холбон судалсан дүн. Вирус судалын тулгамдсан асуудлууд онол практикийн 8-р бага хурал илтгэлийн товч х 3-5, 62-64.
16. Л.Энхбаатар, Н.Дондог , П.Цолмон (1995) Хүн, малын бруцеллез өвчний прогнозлох асуудал Монголын аягаах ухаан №1 х. 20-26
17. Ягодинский.И.В., Ксноваленко.З.П., (1970) Особенности колебаний численности животных и развитие эпизоотии в связи с солнечной активностью Проб.особой опасных инфекций выпуск Саратов. 188с
18. Дуламцэрэн.С., Цэнджав.Д., Авирамэд.Д., (1989) БНМАУ-ын амьтны аймаг хөхтөн амьтан х. 118-119 УБ хот.

ЛЕКЦ, ТОЙМ, ЗӨВЛӨЛГӨӨ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

П.Нямдаваа,
Г.Дашзэвэг
Эрүүл мэндийн яам

Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах явдал төр, засгийн бодлогын нэн чухал хэсэг болж, хүний эрүүл мэндтэй холбогдсон асуудлын бүх талыг хамарсан бодитой тогтолцоо бүрэлдэн хөгжиж ирсэн нь Монгол улсын түүхийн сүүлийн 70 гаруй жилийн маргашгүй чухал ололт мён.

Монгол улсад эрүүлийг хамгаалах явдал уусч хөгжсөн түүхийг 1921 оны ардын хувьсгалын өмнөх че, 1921 оноос хойшхи че гэж өрөнхийд нь хөгжлийн 2 че шат болгон авч үзэж болох юм.

1921 оны ардын ардчилсан хувьсалаас өмнөх че Монгол оронд Дорно дахины анагаах ухаан, ялангуяа монгол, түнд анагаах ухаан хөгжиж, уламжлалт эмнэлгийн арга зүй, дадлагыг эзэмшиэн өмч, маарамба, оточ нар өвдсөн, зовсон хумуусийг гэрээр үзэж өмчлэх эмнэлгийн тусlamжийн өвөрмөц хэлбэр дагнаж байжээ. Улсын эмнэлэг, байгууллага буюу эрүүлийг хамгаалахын бие даасан бүрдмэл тогтолцоо байсангүй. Харин Хаант Оросын консулын газрын болон цэргийн жижигхэн эмнэлгүүд ажиллаж, монгол хумуусийг үзэж өмчилдэг байсан тухай зарим баримт бий.

Олон зуун жилийн түүхтэй монгол, түнд эмнэлэг хүн амын өвчин, эмгэгийг анагаах талаар тухайн цаг үедээ түүхэн түүрэг гүйцэтгэж ирсэн боловч эрүүлийг хамгаалах системтэй арга хэмжээ болж чадаагүй байснаас Монголын хүн амын эрүүл мэндийн түүүнлэлтүүд хэт доод түвшинд байлаа. 1921 оны өмнөх чеийн Монголд хүн амын нас баралт 1000 хүн ам дутамд 25-30-д хурч, шинэ төрсөн 1000 хүүхэд дутмын 500 нь ойндоо хүрэлгүй нас барж, хүн амын дундаж наслалт дөнгөж 32 байв. Цагаан цэцэг, тарваган тахал зэрэг гоц халдварт өвчин газар сайгүй дэгдэлт хэлбэрээр гарч, нийгмийн халдварт өвчинүүд өргөн дэлгэрч байжээ.

Энэ байдлаас дүгнэж үзвэл, Монголд эмнэлгийн тусlamж хөгжсөн түүхэн замналыг Ардын хувьсгалаас хойшхи үед голлон хамааруулж авч үзэх нь илүү зохимжтой юм.

1921 онд Үндэсний ардчилсан хувьсгал ялж, энэ чеэс эхлэн Монгол оронд нийгэм, эдийн засгийн асар их өөрчлөлт гарсны дотор хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн цоо шинэ тогтолцоо бүрэлдэн тогтох че эхэлсэн юм.

Ер нь дэлхий дахины хөгжлийн түүхээс зэдлан шинжилж үзэхэд анагаах ухааны хөгжил, улс орнуудын эдийн засаг, нийгмийн байгуулал, чадавхийн дэвшил нь хүний эрүүл мэндтэй холбогдох бараг бүх асуудлыг нийтийн эрх ашгийн чадлыг төр, засгийн бодлогын хүрээнд авч үздэг болоход хүргэсэн нь тодорхой байна. Ингэснээр одоо үед хүн амынхаа эрүүл мэндийн асуудлыг хариуцсан төр улсын албагийн тусгаар тогтносон улс орон байхгүй болжээ.

Анх 1921 оны 8-р сарын 15-нд Монгол ардын цэргийн дайчид болон ард иргэдэд эмнэлгийн чиэ төлбөргүй тусlamж үзүүлэх "өвчтэй хүмүүсийг эмчлэх Хороо байгуулах тухай" Бүх цэргийн зөвлөлийн тогтооолд их жанжин Д.Сүхбаатар гарын чөг зурснаар Монгол улсад эрүүлийг хамгаалах тогтолцоо, орчин чөийн шинжлэх ухааны эмнэлэг чадлыг хөгжих эх суурь тавигдсан юм. Тиймээс ч энэ өдрийг бид Монгол улсад эрүүл мэндийн улсын алба чадлыг хөгжэж тогтоон билээ.

Харин Монгол улсад хүн амын эрүүл мэндийн асуудал төр, засгийн бодлогын хүрээнд орж албан ёсоор хуульчлагдсан нь 1924 он болно. 1924 оны 11 дугээр сарын 26-нд батлагдсан "БНМАУ-ын Үндсэн хуул"-ийн "Улсын дээд эрхийг барих газрын тухай" хоёрдугаар бүлгийн тавдугаар эйлд заасан "улсын дээд эрхийг хадгалах газрын эрхлэн шийтгэвэл зохих эйлүүд"-ийн арвангуравдугаарт "хүний өвчин эмгэгийг анагаан засах, сэргийлэх дүрэм хэмжээг тогтоох" хэмээн заажээ. Мөн Улсын анхдугаар их хурлын 1924 оны 11 дугээр сарын 13-ны 5 дугаар тогтоолын хоёрдугаар эйлийн тавд "Ардын эрүүлийг хамгаалах... явдлыг цэргийн захиргаанаас Дотоод явдлын яамнаа шилжүүлэн өгч, Ардын эрүүлийг хамгаалах... газрыг байгуулахад бэлтгэвэл зохино" хэмээн заасныг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 1925 оны 7 дугаар сарын 1-ний тогтооолоор Дотоод яамны дэргэд Ардын эрүүлийг хамгаалах газрыг байгуулахаар шийдвэрлэсэн нь манай оронд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг анх бий болгосон нь бөгөөд 1930 онд Улсын зургадугаар их хурлын шийдвэрээр Ардын эрүүлийг хамгаалах яам болон өргөжсөн билээ.

Дотоод яамны дэргэдэх Ардын эрүүлийг хамгаалах газрыг байгуулах тухай шийдвэрт бас заасны дагуу тус газрын Европын батвд ёсны амбулатори болон больниц хэмээх эмчлэн сувилах газруудыг 1925 оны 10 дугаар сарын 20-ны өдөр тус тус нээн байгуулснаас гадна Богдхан, Хан Хэний, Заяын хүрээ, Улиастай, Ховдод 5 эмнэлгийн газар байгуулахаар төлөвлөсөн байна. Гэвч байр олдоогүй, гадаад мэргэжилтэн хүрэлцэн ирж амжаагүй байсны учир дурьдсан 5 газарт тувд ёсны эмнэлэг нээхээр болжээ.

Ийнхүү эрүүлийг хамгаалах төрийн байгууллагыг байгуулсан нь XVII амд эмнэлгийн тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх ариун цэврийн ажлыг сайжруулахад нэлөөлэхийц зохион байгуулалтын чухал алхам болсон байна. Ардын эрүүлийг хамгаалах газар байгуулагдаад газрын дурмийг боловсруулан батлуулж, 1926 он гэхэд эмнэлгийн ажилтан бэлтгэх анхны курсыг зохион байгуулж амжжээ. 1926 онд багтаан 35-аас доош наасны, ажиллаж буй тувд эмнэлгийн эмч нараас 30 хүнийг цуглуулж б сарын хугацаагаар курс хийлгэж, Европын эмнэлгийг мэргэжүүлэх, тувд эмнэлгийг давтан сайжруулахаар тогтоноы дагуу ахмад эмч Д.Рэгзэн тэргүүтэй 23 хүн суралцаж төгссөн нь эмнэлгийн мэргэжлийн үндэсний боловсон хучний анхдагчид байв.

Тус Ардын эрүүлийг хамгаалах газар 1926, 1928, 1929 онуудад Зөвлөлт Оросын эмнэлэг-ариун цэврийн 1,2,3-р экспедицийг хүлээн авч, хамтран ажиллаж, эмнэлгийн цэг салбарыг өргөтгөх ажлын эхлэлийг тавьсан юм. 1929 оноос иргэний больницын дэргэд 2 жилийн хугацаатай сувилагчийн курс байгуулжээ. Мөн онд нянж судлалын лаборатори байгуулсан нь урьдчилан сэргийлэх, оношлох анхны байгууллагын үндэс суурь болсон билээ.

1930 онд байгуулагдсан Ардын Эрүүлийг хамгаалах яам тус улсад XVII амд үзүүлэх эмнэлгийн тусламжийг зохион байгуулалт, арга барил, мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн үүргийг хүлээнээс хойшиж жилүүдэд эрүүлийг хамгаалахын нарийн мэргэжлийн албад, салбаруудыг байгуулах дэс дараатай арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн байна.

1931 онд тарваган тахлын лаборатори, 1932 онд Хүн эмнэлгийн техникум, эмээр хангах газар, 1933 онд бактер шинжилгээний газар, 1941 онд Ариун цэвэр гэгээрлийн ордон, 1942 онд Монгол улсын их сургуулийн анагаах ухааны салбар тус тус байгуулагдаж, улмаар эдгээрээс салбарлан тус улсын эрүүлийг хамгаалахын одоогийн иж бүрэн тогтолцоо бүрэлдэн тогтох хөгжин

бэхжэсээр ирэв.

Эрүүлийг хамгаалах яамны аппарат ч хөгжлийн тухайн че шатны хэрэгцээ, шаардлагад нийцэн бэхжэсээр иржээ. 1932 онд Ардын эрүүлийг хамгаалах яамны эмчлэн сэргийлэх хэлтэс дарга, нэг мэргэжилтэнтэйгээр байгуулагдсан байна. 1938 оноос тус хэлтэс нь эмчлэн сэргийлэх газар болж өргөжин зохион байгуулалт төлөвлөлтийн хэлтэс, эмнэлгийн хэлтэс, ариун цэвэр ба сэргийлэх хэлтэстэйгээр ажиллах болжээ. Аймгуудад эрүүлийг хамгаалах хэлтэс, Улаанбаатарт Эрүүлийг хамгаалах газар байгуулагдсан байна. 1944 оноос Эрүүлийг хамгаалах яам нь коллегитой болсон бөгөөд 1945 онд яамны зохион байгуулалтыг өөрчилж, халдварт өвчинийг эсэргүүцэх хөргийг эрхлэх хэлтэс, хот, хөдөөгийн эмнэлгийн хөргийг эрхлэх хэлтэс, эх нялхсын эмнэлэг, урьдчилан сэргийлэх хэрэг эрхлэх хэлтэс байгуулагджээ.

1948 он гэхэд ЭХЯ 49 орон тоотой болсон ба аймаг, хотын эрүүлийг хамгаалах хэлтсийн дурмийг батлан мөрдүүлсэн байна. Яамны аппарат хөгжлийн тодорхой че шатны зорилтуудтай уялдан өргөжин бэхжэсээр ирсний нэг баримт бол тус яам 1982 он гэхэд 10 газар, хэлтэс, тасагтай ажиллах болсны дотор Улсын ариун цэвэр, халдвэр судлалын байцаан шалгах газар, боловсон хүчин, захиргааны газар, эх нялхсын газар, эмчлэн сэргийлэх хэлтэс (1986 онд газар болж өргөжсэн) төлөвлөгөө, санхүү статистикийн хэлтэс, хөрөнгө оруулалт, материал хангамжийн хэлтэс, гадаад харищааны тасаг, анагаах ухааны эрдэм шинжилгээний тасаг, санхүүтийн хянан шалгах тасаг, аж ахуйн тасаг байв. Одоо Эрүүл мэндийн яам 4 газар, 1 хэлтэстэй.

1930-аад оны үед Монголын төр, засгийн бодлого ЭХЯ-ны үйл ажиллагааны чиглэл нь тус оронд Европ ёсны эмнэлгийг байгуулэх, үндэсний боловсон хүчинийг бэлтгэх, өнгөний өвчинтэй тэмцэх, ариун цэврийг сайжруулах, цагаан цэцэг, галзуу, гэдэсний балнад болон бусад халдварт өвчинтэй тэмцэх ажлыг хүчтэй болгож, вакцин үйлдвэрлэн хүн амыг урьдчилан сэргийлэх тарилгад өргөн хамруулах, эрүүл мэндийн сурталчилгаа, таниулгыг зохион байгуулах, Зөвлөлтийн эмнэлгийн байгууллагатай холбоо тогтоож эмч, мэргэжилтэн урьж ажиллуулах, эмнэлэг-ариун цэврийн экспедиц зохион байгуулж хүн амыг эрүүлжүүлэх явдал байсан байна. Чухамхүү эдгээр зорилтыг амжилттай шийдвэрлэснээр хүн амаа өсгөх төрийн бодлого бодит биеллээ олох байв.

1939 он гэхэд эмнэлгийн салбарын тоо 117-д хурч, 185 суманд сумын сестрагаар толгойлуулсан түргэн тусламж үзүүлэх салбар бий болсон байв. Эмнэлгийн салбаруудын ор 1431, их эмч 83, бага эмч 111, сувилагч 169, сумын сестра 340, багийн сувилагч 169, эх баригч 70, эм найруулагч 25, лаборант 15 бэлтгэгдсэн байв.

1930-1940 онд жил бурийн дундаж өсөлтөөр хүн амын тоо 0,97 хувь, эрүүлийг хамгаалахын зардал 22,4 хувь, эмнэлгийн дунд мэргэжилтний тоо 27,5 хувиар тус тус өссөн бөгөөд нэг их эмчид 6,4 сувилагч ногдох байснаас үзвэл эмнэлэг, чийгчилгээний гол ажлыг сувилагчид гүйцэтгэж байжээ. 13 аймаг, Улаанбаатар, Сүхбаатар хотод эмнэлгийн хэлтэс зохих орон тоотойгоор ажиллан орон нутгийн эмнэлгийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах болов.

1930-аад оны төгсгөл че бол анагаах ухааны шинэ цагийн эмнэлгийн ач тусыг ард түмэн ойлгож, эмнэлгийн байгууллагад туслах хөдөлгөөн орон нутагт өрнөснөөр шинэ дутам байгуулагдсан эмнэлгийн салбаруудыг орон байр, хоол хүнс, аж ахуйн хэрэглэлээр хангахад ихээхэн дэмжлэг болсон он жилүүд байв.

1930 оноос хойшхи 10 жилийн хугацаанд Ардын эрүүлийг хамгаалах яамны сайдаар Д.Пунцаг, Ф.Бадрах, Н.Гонжоон (Ардын гэгээрүүлэх ба Ардын эрүүлийг хамгаалах яам нэгдэн 8 сар ажиллах хугацаанд) Д.Өлзийбат, Ц.Баттөмөр, Санжмятав, С.Галиндив нар, дэд сайдаар Довдооровын Пунцаг, Дамбийням, Дамдин, Ч.Жүгдэрнамжил нар тус тус ажиллаж байсан байна.

1940 оноос хойшхи че болманай оронд эмнэлгийн цэг, салбарын тоо мэдэгдэхүйц өсч бэхжсэн, мэргэжлийн боловсон хүчинийг бэлтгэх тогтолцоо бий болж, боловсон хүчиний хангамж сайжирсан, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлж бодит үр дунд хүрсэн он жилүүд юм. Тухайлбал, 1940 он гэхэд Монгол улс цагаан цэцэг өвчнийг устгасан Ази тивийн анхны орон болов.

1941-1945 он бол Дэлхийн 2-р дайны хунд хэцүү че байсан боловч ЗХУ-ын шууд туслалцаатайгаар БНМАУ-д (хуучин нэрээр) Монгол улсын их сургууль байгуулагдаж, түүнд хүн эмнэлгийн факультет нээгдсэн явдал эмнэлгийн дээд боловсролтой мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх эх уурхай болов. 1940 оноос Хүн эмнэлгийн техникумд 7 жилийн боловсролтой хүүхдийг элсүүлэн сургах болсон нь чанарын томоохон алкам байв. Дайны үед эмнэлгийн салбар, цэгийг өргөтгэх, шинээр байгуулахад хөрөнгө хүч дутагдаж байсан боловч төр, засгаас ард түмний эрүүл мэндийг төр, засгийн бодлогын

гол асуудал болгож байнга анхааран хүч бололцоог дайчилснаар бага эмчийн салбарын тсо 1945 онд 1940 оныхоос 90-ээр нэмэгдэж 257-д хүрчээ. Ардын эрүүлийг хамгаалах яамны бодлогын төвд өнгөний болон халдварт өвчинтэй тэмцэх ажлыг улам хүчтэй болгох явдал байсан бөгөөд энэ тэмцэлд сурталчилгааны ажлыг чиглүүлэн, арга барил нь ч ихээхэн өргөжсөн байна. 1940 онд яамны дэргэд Улсын Ариун Цэврийн Байцаан Шалгах Ерөнхий газар байгуулагдаж, 1941 онд Улаанбаатар хотод Ариун цэвэр гэгээрлийн ордныг байгуулсан нь хүн ардад эмнэлэг, ариун цэврийн мэдлэг боловсрол олгох, ариун цэврийн соёл нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлан таниулж, хэрэгжүүлэх ўйлст чухал нэмэр оруулсаар иржээ.

1946 онд Арье өнгөний больницыг 150 ортойгоор, 1947 онд Халдварт өвчний больницыг байгуулсан нь халдварт өвчинтэй тэмцэх, эмчлэх ажлыг сайжруулах тухайн чийгийн томоохон арга хэмжээ болсон байна. 1948 онд бух аймагт арье өнгөний өвчинтэй тэмцэх тус бүр 2 бригадыг гарган ажиллуулсан бөгөөд аймгийн нэг бригад нь морин өртөөгөөр суманд, сумаас багт хурч узлэг хийж, өвчнийг илрүүлэн эмчлэх ажлыг зохион байгуулж байв. Сумын бригадад нэг бага эмч, нэг сувилагч ажиллан бух арга хэмжээг хэрэгжүүлж байсанас үзвэл манай салбарын дунд мэргэжилтнүүд ямар их үүрэг хүлээж, үр дунтэй ажиллаж чаддагийг нотолж байгаа юм.

Эдгээр бригадыг гаргахын тул Эрүүлийг хамгаалах яам 30 гаруй хүнийг 45 хоногийн тусгай курст суралцуулан сургаж, ажлын заавар, зөвлөлгөөнөөр бүрэн хангаж өгсөн ба үүний дараа арье өнгөний өвчинтэй тэмцэх Монгол-Зөвлөлтийн хамтарсан бригад 36-г 1958-1961 онд ажиллуулснаар хүн амыг эрүүлжүүлэх үндсэн нөхцлийг бурдуулсэн юм.

1948 онд эрүүлийг хамгаалах салбарт хүрсэн түвшинг дараахь байдлаар илрэхийлж болох байна. Үнд; Үндэсний их эмч 36 (бүгд 122 их эмчийн 86 нь Зөвлөлтийн эмч нар байв) бага эмч 371, эх баригч 91, сувилагч 743, эм найруулагч 94, лаборант 67, ариутгагч 36, асрагч 717, гэрлийн техник 3, шүдний техникч 2, багийн сестра 1695, бух ажилчид 4014, эмнэлгийн оп 3162, их эмчийн салбар 39, бага эмчийн салбар 335, сурьеэ эсэргүүцэх газар 2, тахал эсэргүүцэх газар 5, эмийн сан 34, лаборатори 19, хувхийн зөвлөлгөө өгөх газар 27, эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газар 26, ясьль 16, түүний оп 420, эрүүлийг хамгаалахын төсөв 24,5 сая төгрөг, нэг хүнд 31 төгрөг ногдох болов.

1940-өөд оны төгсгөл, 1950-аад оны эхэн чийг хамарсан цаг
ве бол манай орны улс ардын аж ахуйг таван жилийн төлөвлөгөөтэй
хөгжүүлэх тухай удирдах нам, засгийн шийдвэрийн дагуу бүх салбарт
5 жилийн төлөвлөгөө боловсруулах ажил өргөн хүрээтэй хийгдэж,
салбарын хөгжлийн хурсэн түвшинг дүгнэж, цаашдын зорилтод
тодорхойлон дэвшиүүлэх болсон цаг че юм.

Энэ үед Эрүүлийг хамгаалах яам гол анхаарлаа эмнэлгийн
тусlamжийг хөдөөгийн хүн амд ойртуулах асуудалд чиглүүлж аймаг
дундын эмнэлэг байгуулах, аймгуудыг үндэсний мэргэжийн боловсон
хүчинээр хангах ажлыг өргөжүүлэх, сумдад их эмчийн салбар
байгуулж, материаллаг бааз бий болгох, өнгөний өвчнийг устгах,
түргэн тусlamжийн чийгчилгээг өргөжүүлэх талаар шийдвэртэй
алхмуудыг хийсэн байна. Тухайлбал, 1950 онд сурьеэгийн
больниц, 1952 онд Дорнод, Ховд, Архангайд аймаг дундын больниц,
Улаанбаатарт хувьдийн больниц, 1954 онд мэс заслын больниц, Архан-
гай, Дорнотод сувилагийн сургуулиудыг тус тус байгуулжээ. Аймаг,
хотын эрүүлийг хамгаалах хэлтсийн удирдлагыг их эмчээр хангах
зохион байгуулалтын арга хэмжээ авчээ.

1950-1955 онд жил бурийн дундаж өсөлтөөр улсын хүн амын
тоо 1,99 хувь болж хүн ам эрчимтэй өсөх замдаа орсон байна.
Эрүүлийг хамгаалахын төсвийн зардал 13,6 хувь, их эмчийн тоо 22,8
хувь, эмнэлгийн дунд мэргэжилтний тоо 11,6 хувиар тус тус өсч, нэг
их эмчид 6,9 дунд мэргэжилтэн ногдох болов.

Энэ үеэс БНМАУ-ын (хуучин нэрээр) нэр хүнд гадаад
орнуудад өсч байсан таатай боломжид тулгуурлан улмаар эрүүлийг
хамгаалахын гадаад харилцааг хөгжүүлэх асуудалд ЭХЯ онцгой
анхаарал тавих болов.

1940-өөд оноос 1960-аад оны эхэн хүртэлх хугацаанд
Эрүүлийг хамгаалах яамны сайдаар Б.Гонгоржав, Ж.Шинин, З.Дугар,
Г.Туваан нар, дэд сайд, орлогч сайдаар Ж.Шинин, Г.Туваан,
Т.Шагдарсүрэн, Д.Ринчин, Б.Жанчив, Д.Балдандрж, Гомбо,
Д.Түмэндэлгэр, С.Равжаа, Цэрэн, О.Раднаадорж, В.Гаамаа,
Д.Цагаанхүү, С.Шаадай, Д.Самбуу, Б.Дэмбэрэл, С.Вандагдорж нар
тус тус ажиллаж байв.

1966 оноос 1990 оныг хүртэл Эрүүлийг хамгаалах яамны
сайдаар Б.Дэмбэрэл, Д.Ням-Осор, Ч.Цэрэннадмиднаар, орлогч сайдаар
Д.Түмэндэлгэр, С.Шаадай, С.Вандагдорж, Д.Самбуу, Д.Ням-Осор,
Мо.Шагдарсүрэн, Г.Жамба, Б.Жав, Ж.Раднаабазар, Ш.Жигжидсүрэн,
С.Дүгэржав, Ч.Нямдорж, Д.Мөнхөө, П.Нямдаваа нар тус тус

ажиллаж байв. 1990-1992 онд тус яамны орлогч сайд, дэд сайдаар С.Гончиг, Р.Бямбаа, Д.Баярсайхан нар ажиллав.

1966-1973 он бол сум дундын эмнэлгийг нэмэгдүүлэн өргөтгөх, суманд их эмчийн салбар байгуулах, суманд байсан бага эмчийн салбарыг ХАА-н нэгдлийн бригадад шилжүүлэх ажлыг зохион байгуулах, материаллаг баазыг бэхжүүлэх өрнөлтийн он жилүүд байлаа. Энэ хугацаанд эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх, сургах хугацаа, мөргэжил олгох, дээшлүүлэх талаар системчилсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээс гадна анагаах ухааны эрдэм судлалын ажлыг хөгжүүлэхэд ЭХЯ-ны бодлого чиглэгдэж байв.

Эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх талаар 1965 онд БНМАУ-ын (хуучин нэрээр) Ардын Их Хурлын Чуулганаас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой арга хэмжээ авсны дунд Улсын Клиникийн Төв эмнэлэг, Дархан хотын нэгдсэн эмнэлэг, Мөрөн, Чойбалсан хотын нэгдсэн эмнэлэг зэрэг олон томоохон барилга байгууламжийн ажил эхэлж, зарим нь ашиглалтад орсон байна.

Эрүүлийг хамгаалахын зарим үндсэн үзүүлэлтээр жил бурийн дундаж өсөлтийг 1965-1970 оны байдлаар авч үзвэл хүн амын тоо 2,46 хувь, эрүүлийг хамгаалахын төсвийн зардал 7,91 хувь, их эмчийн тоо 8,37 хувь, эмнэлгийн дунд мөргэжилтний тоо 4,55 хувиар тус тус өссөн байна.

Төр, засаг, ЭХЯ-наас энэ жилүүдэд баримталж байсан гол бодлого нь эх нялхсүн эрүүл мэндийг хамгаалах ажлыг улам хүчтэй болгож, нялхсүн эндэгдлийг тууштай бууруулах, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хүчтэй болгож, вакцинуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, нарийн мөргэжлийн тусlamжийн хуртээмжийг сайжруулахад чиглэгдэж байлаа.

1970-аад оны дунд үеэс хойши хугацаанд хөдөөгийн хүн амд эмнэлгийн үйлчилгээг улам ойртуулах, эх нялхсүн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг тодорхой болгох, халдварт өвчинтэй тэмцэх ажилд эргэлт гаргаж, урьдчилан сэргийлэх ажлын үр дунг дээшлүүлэх, анагаах ухааны эрдэм судалгааны ажлын үр өгөөжийг сайжруулах, эрүүлийг хамгаалах байгууллагын материаллаг баазыг улам өргөжүүлэн бэхжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлэхэд бүх ажил чиглэгдэж, мэдэгдэхүйц тодорхой үр дун гарсан бөгөөд төв, орон нутгийн эрүүлийг хамгаалах байгууллагуудын материаллаг бааз ихээхэн сайжрав. Энэ хэрэгт ЗХУ-ын эдийн засгийн буцалтгүй болон техникийн тусlamж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Улаанбаатар хотын Клиникийн 3-р эмнэлэг, Халдвартын больници, Хавдар судлалын

төв, Эх, нялхсүн эрдэм шинжилгээний төв зэрэг томоохон барилга байгууламж баригдаэв.

"БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах хууль"-ийг аялх удаа баталж, улс, олон нийт, аж эхийн байгууллага, ард иргэдийн хооронд эрүүлийг хамгаалаар үүсвэр хүрэлцааг зохицуулаж эрхзүйн үндсийг бий болгосон нь түүхэн чухал арга кэмжээ болсон юм.

Түүнчлэн энэ хугацаанд энчлэх мэндийн тулгамдсан асуудлуудаар улсын хэмжээний хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан нь эрүүл мэндийн бодлогын асуудлууд байв.

Дээр дурдсан баримтад үндэслэн доорхи дүгнэлтийг хийж болоход байна.

Монгол улсад чадвартай болсон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийнхээ эхний 60 гаруй жилд өөрөөр хэлбэл 1990 оныг хуртэл тэр чөлөөнийг засгийн байгууллын хүрээнд социалист эрүүлийг хамгаалах чиг баримжааг баримтлан ажилласан бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээний орчин чөлөөний дэд бүтцийг бий болгож, хүн амд ногдох эмч, эмнэлгийн ажилтны тоо, эмнэлгийн орныхоо тоогоор дэлхийн хөгжилтэй орууудын кэмжээнд хурч, цагаан цэцэг, бээсний (эсэргэнэт) хижиг зэрэг өвчнийг устгаж, нялхсын эндэгдлийг дахин, эхийн эндэгдлийг 4 гаруй дахин бууруулсанар хүн амынхаа тоог 4 дахин өсгөх боломжийг бурдуулсан юм.

Гэвч нийгмийн нийт тогтолцооныхоо адил хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт нь 1970-аад оны тэгсгэлөөс тогтонгошилд орж, оруулсан хөрөнгө оруулалттайгаа тэнцэхүйц үр ашгийг өгч чадахаа болж эхэлсэн билээ. Манай эрдэмтэн, судлаачид, эрүүлийг хамгаалахын зохион байгуулагчид 1980-аад оны сүүлчээс энэ муухардлаас гарах арга замыг эрэлхийлж эхэлсэн бөгөөд нэн тэрүүнд хүн амын эрүүл мэндийг хамгаалахад хувь хүн, хамтлаг (гэр бүл, аж ахуйн нэгж) төр засгийн тэнцүү оролцоог хангаж, эрүүл мэндийн албаны өмчлөл, санхүүжилтын механизмыг олон хэвшилт хэлбэрт шилжүүлэх шаардлагатай гэдэгт санал нийлсэн юм. 1992 онд батлагдсан Монгол улсын шинэ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "(Монгол улсын иргэн)... эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзолжурмыг хуулиар тогтоонсо...", 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...эрүүл мэндээ хамгаалах... нь иргэн бурийн журамт нүүрэг мөн" хэмээн заасан нь дээрх хандлага хууль зүйн дээд

баталгаагаа олсон хэрэг юм. Энэ томъёолол нь цацлаа Монгол улсын бусад хууль тогтоомжууд, тухайлбал, "Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын узэл баримтлал", "Монгол улсын Засгийн гаэрын тухай хууль", "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль", "Төрийн албаны тухай хууль", "Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль" зэргээр тодотгогдох зах зээлийн тогтолцоонд шилжих чийн Монгол орны эрүүл мэндийн бодлогын чндэс суурь болж байна. Монгол улсын сүүлийн гурван Засгийн газар дээрх хуулиудын хүрээнд эрүүл мэндийн тогтолцоог өмчлөлийн болон санхүүжилтын хувьд олон хэвшинжит бүтцэд оруулах, дэлхийн олон орны ялангуяа, шилжилтийн болон эрчимтэй хөгжлийн шатнаа явaa хөгжиж буй орнуудын туршлагыг харгалзан эрүүл мэндийн албаны эдийн засгийн үр ашиг болон анагаах ухааны үр дунг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж ирлээ. Хэдийгээр санхүүжилтын болон материал хангамжийн ихээхэн бэрхшээлтэй тулгарсан боловч орон нутгийн засаг захиргаа, эрүүл мэндийн салбарын ажиллагсдын уйагагүй зүтгэл, дэмжин туслагч олон улсын байгууллагууд, хандивлагч улс орнуудын хүмүүнлэг тусlamжид түшиглэн шилжилтийн энэ чийн туршид эрүүл мэндийн чндсэн үзүүлэлтээ ухраалгүй, дэвшүүлэх замаар авч гарч чадлаа.

Нялхын эндэгдлийн гол шалтгаан болсон амьсгалын замын цочмог халдвэр, суулгарт өвчин, вируст гепатитын тохиолдлыг мэдэгдэхийц бууруулж, 1992 онос улаанбурханаар хувхэд эндэх нь зогсч, 1994 онос полиомиелит буртгэгдэхээ больсноор 1994 оны үзүүлэлтийг 1990 оныхтой харьцуулбал нялхын эндэгдэл 60 гаруй хувь буурч, НҮБ-ын Хувхдийн сангийн ангиллаар нялхын өндөр эндэгдэлтэй орноос дундаж эндэгдэлтэй орны тоонд орлоо. Төрөлтийн тоо нилээд багассан боловч нялхын болон нийт нас бааралтын үзүүлэлт буурч явaa тул хүн амын жил бурийн өсөлт нэг хувиас дээш байгаа нь манай орныг хүн амын өсөлт ихтэй орнуудын тоонд оруулах хэмжээнд байсаар байна.

Гэхдээ энэ бол эрүүл мэндийн бодлого маань бурэн тэгс төгөлдөр болж, бүх юм тэгш сайхан болчихсон гэсэн хэрэг биш ээ.

Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, багаж төхөөрөмж, тургэн тусlamжийн унааны хангамж ихээхэн доройтож,

эмийн болон лабораторийн урвалж бодисын хангамж бүрэн тэгшрээгүйгээс эмчилгээ, оношлогоо саатаж, гэрийн төрөлт, эхийн эндэгдэл нэмэгдэж, хувийн болон хот суурины ариун цэврийн доройтлоос шалтгаалдаг хамуу, цусан суулга, сальмонеллээ, А гепатитийн өвчлөл ихэсч, импортын болон дотоодын чийдэгийн хувь нийтийн чанар, эрүүл ахуйн үзүүлэлтэнд тавих хяналтыг хувь хүрэхгүй, нийгмийн шинэ харилцаанд хөлөө олоогүйгээс архи, мансууруулах бодист донгсон, гудамжинд гарсан, биеэ чиэлэн худалдсан хувь нийтийн тоо нэмэгдэж байгаа зэрэг шийдвэрээ хүлээсэн олон асуудал байсаар байна.

Өөрчлөлт шинэчлэлтийн эхний чийгийн ололтоо бататгаж, амьдралаар шалтгаалдаг, явцгүй нь илэрхий болсон арга барилаа шинэчлэх, боловсронгуй болгох зорилт байдний өмнө зогсч байна. Энэ талаар юун түрүүнд анхаарч эрүүл мэндийн бодлогын хэтийн төлөв болгож хэрэгжүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

Үүнд;

1. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг тухайн нөхцөл байдал, чадавхийн хүрээнд хамгийн үр ашигтайгаар шийдэхэд чиглүүлэн эрүүл мэндийн бүх шатны удирдлагын хүн амзүй, тарвалзий, эдийн засаг, анагаах ухааны технологийн нэгдсэн дун шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх,

2. Хувь хүн, хамтлагийн өөрсдийнхөө болон бусдын эрүүл мэндийн төлөө хүлээх хариуцлага, эрүүл мэндийн мэдлэгийг сайжруулах, нийтийн эдийн засгийн нөхцөлд нийцтэй болгох,

3. Хүн амын төлбөрийн чадвар дээшлэх хирээр эрүүл мэндийн төлбөргүй тусламжаас эмчилгээнд чиглэсэн зардлыг шатчилан багасгаж, улсын нэгдсэн төсвөөс гарах зардлыг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд төвлөрүүлэн эмчилгээний зардлыг даатгал, шууд төлбөрөөр нөхөх чиглэлийг барих,

4. Эрүүл мэндийн ажилтны мэдлэгийн хүрээг дэлхий нийтийн жишигт хүргэж, түүний хэрээр нийгмийн баталгааг нь ч дэлхийн жишигт ойртуулах замаар эмнэлгийн чийдэгийн чанарыг сайжруулах,

5. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн чийдэгийн хүрээ, мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлэх замаар чийдэгийн чанарын төлөө эрүүл мэндийн чийдэгийн хүрээ, эрдэсийн чанарын төлөө эрүүл мэндийн чийдэгийн хүрээ,

6. Эх орны ращаан ус, амьтан, ургамал, эрдэсийн баялгаас

болон биотехнологи, генийн инженерчлэлийн аргаар хүний өвчин, эмгэгийт оношлох, эмчлэх, тэдгээрээс сэргийлэх бэлдмэлийг боловсруулж, практикт нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх,

7. Хамгийн бага зардлаар хамгийн олон хүний эрүүл мэндийг хамгаалах эмнэлгийн чийгчилгээний нэн шаардлагатай багцыг улсын хөмжээнд болон бус нутгаар тодорхойлсны үндсэн дээр эрүүл мэндийн санхүүжилтийг байгууллагаар хийдэг зарчмыг халж, тодорхой хугацааны дотор хүрэх үр дүнг зорилтот хөтөлбөрөөр буюу нэг иргэнд ногдох зардлаар тооцдог дэлхий нийтийн хандлагыг өөрийн орны нөхцөл токируулан нэвтрүүлэх.

8. Эмнэлэг, чийгчилгээний ажилд нийгмийн шудрага ёсыг тогтоон хэвшүүлж, хүн амын эмзэгт хэсгийн эрүүл мэндийг баталгаатай хамгаалах тогтолцоог бий болгох. Энэ зорилгоор хувийн хэвшлийн чийгчилгээний нэгжийг шинээр бий болгох зөвшилцөрөл, шийдвэр гаргахдаа ажиллагсдынхаа болон нийгмийн эрүүл мэндийн асуудлаар хүлээх нүүрэг, хариуслагыг яв цав хүлээлгэсэн байх зарчмыг хуульчлан тогтоох.

9. Эрүүл байх үндсэн нөхцөл нь амьжиргааны тувшин ямагт сайжирч байх явдал мөн гэдгийг нийгмийн бодлого болгож, ядуурлыг багасгах, арилгах арга хэмжээг туштай хэрэгжүүлэх. Энэ хүрээнд ядуурлыг бууруулах Үндэсний боллон орон нутгийн хөтөлбөрүүдийг эмнэлэг, чийгчилгээний үндсэн зорилтуудыг хангах ажилтай нягт холбон уялдуулж хэрэгжүүлэх.

Ядуучуудын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн хамгааллын аюулгүйн сүлжээг бий болгох.

10. Эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг хөгжлийн чадвартай нийтийн төслийн төгрөгчийн төрөлд зонхилох шалтгаан болж буй 10 өвчний бүртгэн тогтоож, тэдгээртэй тэмцэх тодорхой хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зэрэг болно.

ABSTRACTS

POSSIBILITIES OF USAGE OF HUMANITY TESTS IN THE SELECTION OF FUTURE SPECIALISTS

G.Sukhbat, O.Amartsengel, G.Batmunkh, G.Dashzeveg
Mongolian Medical University

We have investigated 1440 students of Mongolian National University, Mongolian Medical University, Mongolian Agricultural University, Mongolian Pedagogical University and Technical University by the Humanity test (that we worked out), Doletsky test of health worry, character test of Smirnov, and we have made the cluster analysis by sex, profession, admission. The results show that $43\pm4.71\%$ of medical students and $5\pm0.4\%$ of other students have high score in humanity test. Also in that way higher score in humanity estimated in male students from rural area and female students from urban area. From those and other results of investigation we did the conclusion. It is clear in the selection of profession the usage of Humanity test is important.

pp15-19, Tables 2, References 5.

THE RESULTS OF A STUDY ON CURVATURE OF SPINE OF MONGOLIAN CHILDREN

S.Tatyana, B.Burma, T.Tungalag, A.Choigoljamts,
TS.Adyahuu, Ts.Jargalsaikhan, I.Narantsetseg, T.Nansalma

National Center of Hygiene, Epidemiology, and Microbiology, Department of Hygiene and Epidemiology of the Uvs, Khovd, Uvurhangai, Bulgan and Arhangai aimaks and Ulaanbaatar city

The result of the study shows, that 83.7 per cent of the all investigated shcoolchildren have normal curvature of spine, 14.64 per cent has some deviations and 1.63 per cent has considerable deviation.

Disorders of physical stature among school children of Ulaanbaatar city are more 14.1 per sent than in preschool children.
pp.19-25, Tables 3, References 6.

THE RESULTS OF A STUDY ON CORRELATIONS OF CONTENTS OF BIO-ACTIVE ELEMENTS IN THE DRINKING WATER AND MORBIDITY OF POPULATION

**L.Narantuya, Sh.Enkhtsetseg, L.Purevjaw, T.Toiwgoor,
G.Tuwaanjaw, A.Bathishig**

*National Center of Hygiene Epidemiology and Microbiology,
Ministry of Health*

38.5% of Mongolian somons population use drinking water which not complaid hygienic requirements by one or several indications.

The total appearance some cases of circulatory system diseases have negative correlation in medium level with the growth of total dissolved solid of drinking water.

The sum total appearance some cases of digestive and genitourinary systems diseases have direct correlation with the growth of total dissolved solid of drinking water.

pp.19-25, Tables 3, References 6.

STUDY OF INFLUENCES OF SOME NATURAL FACTORS ON PLAGUE OUTBREAKS IN MONGOLIA

L.Enkhbaatar, L.Lkhagwa

*National Center of Hygiene, Epidemiology and Microbiology,
Ministry of Health, Mongolia, Mongolian Medical University*

It has studied the correlation of 113 cases of plague outbursts with solar activity in Mongolia. The author has revealed 4,9,11,22,3,,44 years cycles of increase if 22,44 years authors cycles were marked at high degrees of Wolf's Numbers, for last 30 years they have been moved to low periods of solar activity. The author has concluded that outburst of 1993 was increase of following 44 year cycles.

pp.26-32. Diagrams 3, References 18.

THE HISTORICAL DEVELOPMENT AND THE FUTURE TRENDS IN HEALTH POLICY OF MONGOLIA

P.Nymadawa, G.Dashzeveg
Ministry of Health Mongolia

This paper reviews historical development of health policy in Mongolia during the last 70 years and draws priorities in the health care policy in current situation of the country.
pp.33-44.

1995 ОНД АНАГААХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД

Нэг.Докторын зэрэг хамгаалсан эрдэмтэд

1. ДОРЖСҮРЭНГИЙН АМГАЛАНБААТАР Анагаах Ухааны Их Сургууль (Докторант)

Урьгал мэдрэлийн зэт тогтолцооны идэвхи сул нөхцөлд нүдний салст, зүрхний булчингийн бичил судасны торны төгөлдөржсөн загвар бүрэлдэх явц сэдвээр 1995 оны 4 сарын 6-нд Улаанбаатар хотод хамгаалсан.

Судлаач энэхүү бүтээлэрээ хүн ба амьтанд зүрхний булчин, нүдний салстын бичил судасны торны бүтэц, түүний төгөлдөржин хөгжих явцыг судлан тогтоож улмаар урьгал мэдрэлийн зэт тогтолцооны идэвхийг дарангуйлсан нөхцөлд зүрхний булчин нүдний салстын бичил судасны бүрэлдэх явц хэрхэн өөрчлөгдхөйг түршилт судалгаагаар тогтоосон байна.

2. БЭГЗСҮРЭНГИЙН ДАГВАЦЭРЭН Уламжлалт эмнэлэг, рашаан судлалын үндэсний хүрээлэн (Докторант)

Монгол төвдийн уламжлалт анагаах ухааны онол арга зүйн үндсэн зүй тогтол сэдвээр 1995 оны 9 сарын 14-нд Улаанбаатар хотод хамгаалжээ.

Судлаач энэхүү бүтээлэрээ орчин үеийн тогтолцооны ерөнхий онол ба синергетикийн хандлагага, арга зүйн үүднээс Монгол төвдийн уламжлалт анагаах ухааны онол арга зүйн гол ойлголтууд, үзэл баримтлалд хэрэгжиж буй зүй тогтол, зарчмыг тогтоосон байна.

Хоёр.Дэд докторын зэрэг хамгаалсан эрдэмтэд

ДАШДОРЖИЙН ЦОЛМОН Анагаах ухааны их сургуулийн морфологийн тэнхимийн багш (аспирант)

Эт мэдрэлийн системийг дарангуйлах нөхцлийн (десимапатизаци) өндгөвчний морфогенез ба гистофизиологи сэдвээр 1994 оны 3 сарын 14-нд ОХУ-ын Москва хотод хамгаалжээ.

Эт мэдрэлийн систем нь өндгөвчний эрт хөгжил, үйл ажиллагаа, фолликулогенезд чухал нэлэө үзүүлдэг болохыг, эт мэдрэлийн системийг дарангуйлсан түршилт, сорилоор баталжээ.

ЦЭРЭННАДМИДЫН ЭНСКАРГАЛ Хоол судлалын төвд эрдэм шинжилгээний ажилтан (аспирант)

Эрүүл ба эмгэгтэй Монгол хүмүүсийн амин хүчлийн судалгаа сэдвээр 1995 оны 4 сарын 21-нд Чех улсын Прага хотод биологийн ухааны дэд докторын зэрэг хамгаалжээ.

Эрүүл болон эмгэг өвчинтэй Монгол хүмүүсийн үндсэн 16 төрийн аминхүчлийн агууламжийг судлах Монгол хүмүүст дээрх аминхүчлийн алдагдал үүгий болохыг тогтоожээ. Эдгээр амин хүчлүүдийн агууламжийг судлах шинжилгээний арга зүй боловсруулан практикт нэвтрүүлжээ.

Дэд докторын зэрэг хамгаалсан эрдэмтэд (Үргэлжлэл)

МЯНГАНБУУГИЙН ЭНХТУУЛ

**Эх Нялжын Эрдэм Шинжилгээний Төвийн
нүдний эмч (аспирант)**

Монгол хүүхдийн нүдний хүнд гэмтлүүдийн тавилан, клиник-эпидемиологийн онцлог сэдвээр 1995 оны 6 сарын 6-нд ОХУ-ын Москвагийн Гельмольцийн нэрэмжит нүд судлалын хүрээлэнд хамгаалжээ.

Монгол усад хүүхдийн нүдний гэмтлийн тархалт, эмнэлэзүйн онцлог, гэмтлийн тавиланг судлаж, цашид нүдний гэмтлээс болон түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга эзүй боловсруулсан байна.

ГАНБААТАРЫН ЭРДЭНЭТҮЯА

**Анагаах Ухааны Их Сургуулийн хүүхдийн өвчин
судлалын тэнхимийн багш (аспирант)**

Арал орчмын хямралын бүсийн хүүхдийн бие бялдрын хөгжилт ба бэлгийн бойжилт сэдвээр 1995 оны 9 сарын 27-нд Казакстан улсын Алма-Ата хотод хамгаалжээ.

Хийсэн судалгааны үр дунд Арал орчмын хямралын бүсэд бий болсон экологийн тааламжгүй нөхцөл байдал нь, энд амьдарч буй хүүхдийн бие бялдрын хөгжилт, бэлгийн бойжилтонд сөрөг нөлөө үзүүлж байгааг илрүүлсэн нь дотоод шүүрлийн даавруудад гарсан өөрчлөлттэй холбоотой болохыг нотолсон байна.

ДАГВЫН ХИШГЭЭ

**Ардын эмнэлгийн хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан (горилогч)**

Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэж байсан дэгдийн хоёр зүйл ургамлын фитохимиийн судлагаа сэдвээр 1995 оны 11 сарын 1-нд Улаанбаатарт эм зүйн ухааны дэд докторын зэрэг хамгаалжээ.

Дэгдний хими, фармакологи, фитохимиийн судалгааг цогцолбороор явуулж, дэгдээс "силодин" гэдэг эм бэлтгэн гаргаж авсан нь цэс хөөх, элэг хамгаалах, элэгийн үрэвслийн эсрэг үйлчилгээтэйг баталсан бөгөөд уг эмийн технологийн заавар боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлж, эмийг эмчилгээний практикт нэвтрүүлсэн байна.

ХАЙНЗАНГИЙН ЖАМБАЛМАА

**Эрүүл ахуй Халдвэр, нян судлалын үндэсний төвд
эрдэм шинжилгээний ажилтан (горилогч)**

Монгол үндэсний уламжлалт аргаар бэлтгэсэн цагаан идээний хөгцөм мөөгөнцөрийн судалгаа сэдвээр 1995 оны 12 сарын 27-нд Казакстан улсын Алма-Ата хотод хамгаалжээ.

Монголын уламжлалт аргаар бэлтгэсэн цагаан идээний зүйл хүнсний бутээгдхүүний хөгцөн мөөгөнцөрийг судлаж, хадгалах хугацаанд хөгцөн мөөгөнцөрийн үүсэх өрөнхий зүйл тогтолыг илрүүлж, хүнсний зүйлд агуулагдах хөгцөн мөөгөнцөрийн хүний эрүүл мэндэд нөлөөлөх, өвчин үүсгэх боломжийг судлажээ.

МОНГОЛЫН АНАГААХ УХААН СЭТГҮҮЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮД

П.Нямдаваа (Ерөнхий эрхлэгч), Б.Дэмбэрэл (Орлогч эрхлэгч),
Ш.Доржадамба (Орлогч эрхлэгч), В.Хадхүү (Хариуцлагатай
нарийн бичгийн дарга), Р.Арслан, Ж.Батсуурь, Б.Гоош, А.Ламжав,
Э.Лувсандагва, Ф.Өлзийхутаг, Г.Тойвгоо, Ц.Хайдав, Ж.Шагж,
Б.Шижирбаатар, Г.Цагаанхүү

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

С.Алтан (АНУ Нью Жерси), Д.Балдандорж, М.Гретт (АНУ,
Миннесота), Б.Дагвацэрэн, Ж.Дашдаваа, Б.Доржготов, Б.Жав,
Ш.Жигжидсүрэн, Г.Зориг, Т.Зориг, Г.Лувсан, (Оросын холбоо,
Москва), Д.Малчинхүү, Н.Мөнхтүвшин, Ц.Мухар, Б.Нацагдорж,
Ц.Норовпил, П.Онхуудай, Э.Пүрэвдаваа, Б.Рагчаа, Э.Санжаа,
Г.Сүхбат, С.Цоодол, Л.Шагдар

МАНАЙ ХАЯГ:

Улаанбаатар-210648, ЧИНГЭСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ
"Эрүүл Энх" хэвлэлийн газар Утас: 321307

Техник редактор Ф.Бямбажаргал

Сэтгүүлийн компьютерт 12 сард бэлтгэж хэвлэлтэд шилжүүлэв.

Цаасны хэмжээ 60 х 90 1\16 хэв. хуудас 3.00